



ЖЕНДЭРИЙН
ҮНДЭСНИЙ
ХОРОО



ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖ, ЁС ЗҮЙТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ

РЕДАКЦУУДАД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ

Удирдамжийг боловсруулсан

Д.Мөнхчимэг

Хянан тохиолдуулсан

Жендэрийн үндэсний хороо:

Жендэрийн үндэсний шинжээч Б.Онон
Ажлын албаны мэргэжилтэн Б.Анхзаяа

Хэвлэл мэдээллийн зөвлөл:

Гүйцэтгэх захирал
Г.Гүнжидмаа

Зөвлөх багийн гишүүд:

А.Амартүвшин
О.Ариунбилэг
Д.Нарантуяа
Ц.Оюунтунгалаг
Б.Ундрахжаргалант
Э.Энэрэл

Жендэрийн үндэсний хороо, 2021 он

Энд илэрхийлсэн үзэл санаа нь зохиогчдынх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй.

Энэхүү удирдамжийг НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй «Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь» төслийн хүрээнд бэлтгэв.



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН УДИРТГАЛ	5
Нэгдүгээр бүлэг. РЕДАКЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ	5
Жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	9
Редакцын үйл ажиллагаан дахь жендэрийн тэгш байдлыг дэмжих тусгайлан зөвлөмжүүд	10
Хоёрдугаар бүлэг. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ	13
Чиг хандлага: Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах	15
Шинэ өнцөг: Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах	18
Жендэрийн тэгш байдлыг хангах тал дээр “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэх	20
Гуравдугаар бүлэг. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУРВАЛЖЛАХ НЬ	23
Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх хэвшсэн буруу ойлголт, хандлага	25
Ёс зүйн хэм хэмжээ ба даван туулагч төвтэй арга зүй	27
Жендэрт суурилсан хүчирхийллийг сурвалжлахдаа баримтлах зөвлөмж	28
ХАВСРАЛТ	34
Хавсралт 1. Жендэрийн нэр томъёоны товч тайлбар	34
Хавсралт 2. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, тоон мэдээлэл	35
Хавсралт 3. Ярилцлага авах зөвшөөрлийн хуудасны загвар	38
Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	39
ЭХ СУРВАЛЖ	41

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т тусгасан жендэрийн тэгш байдлыг хангах тухай тавдугаар зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчин бүрдүүлэх зорилтын хэрэгжилтийг хянаж, олон нийтэд ойлгуулахад хэвлэл мэдээллийн салбар чухал үүрэгтэй.

Бодит байдлыг сурвалжлан мэдээлэхдээ хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл буруу ойлголтын золиос болгохгүй байх нь хэвлэл мэдээллийнхний мэргэжлийн, ёс зүйн шаардлага юм. Гэвч Монгол төдийгүй дэлхий даяар сэтгүүл зүйн салбарынхан эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, жендэрийн хэвшмэл ойлголтыг халах, ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллийг мэдээлж, сурвалжлах тал дээр ёс зүйн алдаа гаргах тохиолдол элбэг.

Иймд, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг дэмжих нь Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хувьд чухал зорилт юм. Жендэрийн тэгш байдалд дэлхий нийт улам ихээр анхаарлаа хандуулж байгаа өнөө үед олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь шинэ чиг хандлага болж буй. Мөн жендэрт суурилсан хүчирхийллийг ёс зүйтэйгээр мэдээлж, сурвалжлах, улмаар энэ төрлийн

гэмт хэргийг таслан зогсоох чиглэлд ч хэвлэл мэдээллийн байгууллагууд идэвхтэй оролцож эхэллээ. Монголын редакцууд болон сэтгүүлчид энэ тал дээр туршлага судлах, дагаж мөрдөх нөөц хэрэглэгдэхүүн, бодлогын баримт бичиг ховор байна. Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллийн чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлчдийн хувьд сургалтаас олж авсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан ажилладаг бөгөөд гарын дор ашиглах удирдамж үгүйлэгдэж байна.

Иймд, Жендэрийн үндэсний хороо болон НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс редакцуудад зориулж энэхүү удирдамжийг эрхлэн гаргалаа. Олон улсын туршлага, дотоодын нөхцөл байдалд тулгуурлан боловсруулсан энэхүү удирдамжид редакцын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах, хэвлэл мэдээллийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэйгээр бүтээх, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг ёс зүйтэйгээр сурвалжлах гэсэн гурван бүлгийг багтаав.

Бид эдгээр мэдээллээ цаг нартай уралдан ажилладаг мэдээллийн редакцуудын завгүй хэмнэлд нийцсэн, ашиглахад дөхөм гарын авлага хэлбэрээр танд хүргэхийг хичээлээ. Энэхүү удирдамжийг редакцын нийтлэлийн бодлогодоо тусгаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр жендэрийн тэгш байдлыг хангахад танай байгууллага тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН УДИРТГАЛ

АЛИВАА АСУУДАЛ,
СЭДВИЙГ ЖЕНДЭРИЙН
ЛИНЗЭЭР ХАРЖ ШИНЖИХ
НЬ ТУХАЙН СЭДВИЙГ
БҮРЭН БҮТНЭЭР НЬ
МЭДЭЭЛЭХЭД АМИН
ЧУХАЛ. МЭДЭЭГ ИЛҮҮ
ТЭНЦВЭРТЭЙ, ОЛОН
ТАЛЫН ОРОЛЦООГ
ХАНГАСАН БАЙЛГАХЫН
ТУЛД ЮУ МЭДЭЭ БОЛОХЫГ
ШИЙДЭХЭЭС ЭХЛЭЭД
ХЭРХЭН ТҮҮНИЙГ ХИЙХ
ХҮРТЭЛХ БҮХИЙ Л ЯВЦАД
ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ
БАЙХ ХЭРЭГТЭЙ.

Сэтгүүлчдийн бэлтгэн нийтэлж, түгээж буй мэдээ, мэдээлэл нь Ялгаварлан гадуурхалт, жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид байх төдий бус, эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг анхааран харгалзаж, тэдэнд тэгш боломж, сонголт олгох нийгмийн хандлага, сэтгэлгээний соёлыг төлөвшүүлэх хүчирхэг хэрэгсэл билээ. Жендэрийн зөрүү, ялгаатай байдлыг бодитоор харуулахаас илүүтэй өөрчлөн сайжруулахад сэтгүүл зүй асар их хувь нэмэр оруулах боломжтой. Харамсалтай нь дэлхий дахины сэтгүүл зүйн үйл ажиллагааны бүхий л түвшинд жендэрийн тэгш байдлыг хангахад мэдрэмж муутай хандаж ирсэн. Тиймээс 1995 онд Бээжинд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн асуудлаарх НҮБ-ын бага хурлаар баталсан Бээжингийн Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт мэдээллийн салбарыг тулгамдсан 12 салбарын нэг болгон онцолж, тус салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдлыг дэмжиж, хэвшмэл ойлголтуудыг халах стратегийн хоёр зорилго тавьжээ (Fourth World Conference on Women, 1995). Үүнээс хойш эмэгтэй сэтгүүлчдийг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх ажлууд олон улсын хэмжээнд хэрэгжсэн ч ахиц дэвшил чамлалттай байгаа юм.

Таван жил тутам мэдээний мониторинг хийдэг Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төслөөс эмэгтэйчүүдийн дуу хоолойг гаргах тал дээр хэвлэл мэдээллийн салбар хойрго байгааг анхааруулдаг. 1995 онд энэхүү мониторингийг анх хийхэд мэдээний субъект буюу мэдээгээр гарсан хүмүүсийн ердөө 17 хувь нь эмэгтэйчүүд байж. Үүнээс хойш 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт 25 хувьд хүрч, олигтой өссөнгүй. Энэ чигээр ахиц удаан байвал мэдээний агуулгад жендэрийн тэгш байдлыг харахын тулд бид дор хаяж 67 жил хүлээхэд хүрнэ (GMMP, 2020).

Жендэрт суурилан ялгаварлан гадуурхахгүй байх нь сэтгүүлчдийн мэргэжил, ёс зүйн стандартын чухал шаардлага юм. Олон улсын сэтгүүлчдийн нэгдсэн холбоо 1954 онд “Сэтгүүлчид ялгаварлан гадуурхалтыг дэвэргэх аюул байгааг мэдэж, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, бусад зүйлд суурилсан ялгаварлан гадуурхалтаас зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийнэ” гэж тунхагласан байдаг.

Тэгвэл Монголын Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын гуравдугаарт “Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй” гээд 3.2-т “Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ” гэж заасан.

Харамсалтай нь, энэ стандарт бодит байдал дээр хэрэгжихгүй байгааг бид харж байна. Дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хангалттай илэрхийлж чадахгүй байна гэдэг нь сэтгүүл зүй үнэн бодит байдлыг тусгах, нийгмийн толь болох үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн үг. Нөгөө талд эрэгтэйчүүд, ЛГБТИК хүмүүсийн хувьд тулгамдсан асуудлууд мэдээний сэдвээс орхигдсон хэвээр байна. Энэ бүхэн Монголд төдийгүй дэлхий даяар хэвлэл мэдээллийн салбар алдаа дутагдлаа олж харж, засахгүй байгааг илэрхийлнэ.

Харамсалтай нь, энэ стандарт бодит байдал дээр хэрэгжихгүй байна. Дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хангалттай илэрхийлж чадахгүй байгаа нь сэтгүүл зүй үнэн бодит байдлыг тусгах, нийгмийн толь болох үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн үг. Мөн эрэгтэйчүүд, ЛГБТИК хүмүүсийн тулгамдсан асуудлууд мэдээний сэдвээс орхигдсон хэвээр байна. Энэ бүхэн Монголд төдийгүй дэлхий даяар хэвлэл мэдээллийн салбар алдаа дутагдлаа олж харж, засахгүй байгааг илтгэнэ.

Сэтгүүл зүйн салбарынхны дунд жендэр гэдэг нь тусдаа сэдэв бөгөөд түүгээр дагнасан сэтгүүлчдэд л хамаатай, цаг үеийн мэдээ зэргийг хийхэд энэ талаар боловсрол хэрэггүй гэсэн ойлголт байдаг. Гэтэл аливаа асуудал, сэдвийг жендэрийн линзээр харж шинжиж байж бүрэн бүтнээр нь мэдээлэх боломжтой. Мэдээг илүү тэнцвэртэй, олон талын оролцоог хангасан байлгахын тулд юу мэдээ болохыг шийдэхээс эхлээд хэрхэн түүнийг хийх хүртэлх бүхий л явцад жендэрийн мэдрэмжтэй байх хэрэгтэй. Энэ нь зөвхөн сурвалжлагчид төдийгүй редакторууд, зураг дүрсний мэргэжилтнүүд зэрэг мэдээ хийхэд оролцож байгаа хүн бүрд хамаатай.

Монгол Улсад жендэрийн бодлого төлөвлөлт, тогтолцоо улам боловсронгуй болж буй энэ үед бид хэвлэл мэдээллийн салбарт жендэрийн

асуудлыг хүйсийн тоон харьцаа, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэхээр хязгаарлалгүй, монгол эмэгтэй, эрэгтэй хүмүүст тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хэм хэмжээ, нийтлэг үнэт зүйлд нийцүүлэн, улс орныхоо онцлог байдлыг харгалзсан идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлэх шаардлагатай байна.

Редакцын үйл ажиллагаа, нийтлэлийн бодлогод жендэрийн тэгш байдлыг тусгахад хувь нэмэр оруулах жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн удирдамжийг дараах судалгаа, тайланд тулгуурлан боловсрууллаа. Үүнд:

-“Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт” (ЮНЕСКО, Глоб Интернэшнл Төв, 2014);

-“Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй болон редакцын бодлогын сурах бичиг” (WACC/IFJ, 2012);

-“Бодит байдлыг тусга” (Internews, United for News) гарын авлага;

-“Мэдээнд үгүйлэгдсэн эмэгтэйчүүдийн байр суурь” (Kassova, 2020) судалгааны тайлан.

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн удирдамжийг олон улсын туршлагаас судлахын зэрэгцээ дотоодын нөхцөл байдалтай уялдуулж боловсруулсан бөгөөд үүнийг гурван үндсэн бүлэгт хувааж гаргав. **Нэгдүгээрт**, редакцын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах зөвлөмжүүдийг холбогдох нөөц хэрэглэгдэхүүний хамт хүргэхийг зорилоо. **Хоёрдугаарт**, хэвлэл мэдээллийн агуулгад жендэрийн эрх тэгш байдлыг хангах олон улсын тэргүүн туршлага, зөвлөмжүүдийг толилуулав. **Гуравдугаарт** бүлэгт сэтгүүлч, редакторуудад зориулан жендэрт суурилсан хүчирхийллийг сурвалжлах ёс зүйн хэм хэмжээ, арга зүйн зөвлөмжүүдийг танилцуулав.

Нэгдүгээр бүлэг

РЕДАКЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээх мэдээллийн бодлого, агуулгыг тодорхойлогч нэгж болох редакцын үйл ажиллагааны бүх хүрээ, үе шатанд жендэрийн тэгш байдлыг хангах соёл, хандлагыг төлөвшүүлэх нь хамт олны дотоод уур амьсгал, ажлын бүтээмжид эергээр нөлөөлөхөөс гадна мэдээ мэдээллийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох зайлшгүй урьдач нөхцөл болно. Редакцын үйл ажиллагаан дахь жендэрийн тэгш байдал нь нийт ажилтнуудын хүйсийн харьцаа төдийгүй аюулгүй байдал, цалин хөлс, шагнал урамшуулал, сурч боловсрох, албан тушаал ахих боломж, ажлын орчин нөхцөл, мөн ажилхувийн амьдралаа тэнцвэртэй зохицуулах зэрэг олон зүйлийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарна. Харамсалтай нь, эдгээр үзүүлэлтээр хийсэн үнэлгээ, судалгаа хомс бөгөөд олон улсад хүйсийн харьцааны талаарх мэдээ мэдээлэл хамгийн түгээмэл байна.

1995 онд олон улсын хэмжээнд сурвалжлагчдын 28 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 40 хувьд хүрч өссөн байна (GMMP, 2020). Сэтгүүл зүйн чиглэлээр суралцах, ажиллах эмэгтэйчүүдийн тоо сүүлийн арав гаруй жилд мэдэгдэхүйц нэмэгдсэн ч хэвлэл мэдээллийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийх ажил их байна.

Тухайлбал, 2019 онд Олон улсын сэтгүүлчдийн төлөө төвийн явуулсан “Олон улсын редакцууд дахь технологийн байдал” судалгаанаас үзэхэд редакцын сэтгүүлч, менежерүүдийн 61 хувь нь эрэгтэйчүүд, 39 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Редакц дахь эмэгтэйчүүдийн оролцоо Хойд Америк, Европт эрэгтэйчүүдийнхээс давсан ч бусад бүс нутаг, ялангуяа Ази, Африкт хангалтгүй хэвээр байна (ICFJ, 2019). Олон улсад эмэгтэйчүүд сэтгүүл зүйн удирдах ажилтнуудын 26 хувийг л бүрдүүлж байна (Kassova, 2020).

Иймд хэвлэл мэдээллийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэй сэтгүүлчдийг дэмжих, цалин хөлсний ялгааг арилгах нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал

хэвээр байна. Харин Монгол Улсад байдал харьцангуй өөр байгаа юм.

“Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлангаас үзэхэд 2019 оны байдлаар хэвлэл мэдээллийн салбар дахь бүтээлч ажилтнуудын (сэтгүүлч, сурвалжлагч, найруулагч, редакторууд) 62 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Түүнчлэн радио, телевизийн салбарын шийдвэр гаргах түвшний удирдах ажилтнуудын 49 хувийг, сонин, сэтгүүл болон мэдээллийн сайтуудын хувьд талаас илүү нь эмэгтэйчүүд байгаа (Хэвлэлийн хүрээлэн, 2020). Хэдийгээр энэ нь чухал үзүүлэлт боловч энэхүү тоон харьцаа дангаараа хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдлыг илэрхийлж чадахгүй. Үүний цаана ажлын орчин нөхцөл, аюулгүй байдал, мэргэжлийн ур чадвараа сайжруулах тэгш боломж, мөн нийтлэл нэвтрүүлгийн жендэрийн мэдрэмжтэй бодлого, ажилтнуудын жендэрийн мэдрэмж, мэдлэг, ур чадвар зэрэг олон зүйлийг бодолцох шаардлагатай.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгаанаас үзэхэд ямар нэгэн байдлаар дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүсийн олонх нь эмэгтэйчүүд болон 30 хүртэлх насны залуучууд байна (ФЭС, Хэвлэлийн хүрээлэн, 2019). Тэгвэл “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг” судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 22 хувь нь ажлаа хийж байхдаа эх сурвалжийн зүгээс үзүүлсэн бэлгийн дарамтын шинжтэй үйлдэлд өртөж байсан гэж хариулжээ. Мөн 18 хувь нь бие эрхтэнд халдаж байсан, 14 хувь нь ажлын байрны бэлгийн дарамтад өртөж байсан гэсэн байна. Бие эрхтэнд нь ямар нэг байдлаар халдаж байсан тохиолдол эмэгтэй сэтгүүлчдэд эрэгтэйчүүдээс хоёр дахин их буюу дөрвөн удаагийн давтамжтай тохиолджээ (Глоб Интернэшнл, 2019).

Ажлын байрны бэлгийн дарамт, үзэн ядах үг хэллэг, доромжлол зэрэгт эмэгтэй сэтгүүлчид хавьгүй элбэг өртдөг болохыг анхаарч, тэднийг хамгаалах тогтолцоотой болох нь жендэрийн

тэгш байдлыг дэмжих нэг том алхам юм. Мөн эрэгтэй сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтнуудын тоо сүүлийн жилүүдэд цөөрч байгаа шалтгааныг судлах, салбарын эрэгтэйчүүдэд тулгамдаж буй бэрхшээлүүдийг тодорхойлох хэрэгцээ шаардлага бий болж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

Жендэрийн тэгш байдлыг хангах гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд тусган шийдвэрлэх, байгууллагын үйл ажиллагаанд нийт ажиллагсдын оролцох тэгш боломжийг сайжруулах, ялгаатай байдлыг хүндэтгэх өргөн агуулга бүхий үйл явц юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хууль, үндэсний болон салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтөд эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээ, тулгамдсан асуудлыг эн тэнцүү харгалзан анхаарах “Жендэр ба хөгжил” хандлагыг баримталж байна. Энэ хандлагыг бодит ажил хэрэг болгохын тулд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд нэвтрүүлэх (Gender mainstreaming) хэрэгтэй. Жендэрийн асуудлаар нэг удаагийн, эсвэл тодорхой хугацаа, сэдэв, хүрээг хамарсан арга хэмжээ зохион байгуулаад өнгөрөх биш, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг тогтвортой хангах, гүн бат суулгах ач холбогдолтой. Энэ стратегийг ашиглах хамгийн энгийн, түгээмэл, үр дүнтэй арга бол байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх явдал юм.

Редакцын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах гэдэг нь хүйс, эсвэл бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн бүр аюулгүй, таатай орчинд ажиллаж, амжилтад хүрэх тэгш боломжийг бүрдүүлэхийг хэлнэ. Үүний тулд үндэсний болон салбарын түвшинд жендэрийн ямар тулгамдсан асуудал байгааг анхаарч, өөрийн байгууллагад жендэрийн ямар бэрхшээлтэй асуудал байгааг судлан

тогтоож, байгууллагынхаа хэрэгцээ шаардлагад тохирсон зорилго зорилтууд тавьж, тэдгээрт хүрэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх нь чухал. Энэ ажлыг эхлүүлэхдээ танай байгууллага жендэрийн тэгш байдлыг хэр хангаж байгаагаа Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг (ЮНЕСКО, Глоб Интернэшнл Төв, 2014) ашиглан хэмжиж үзэж болно. Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг ганц удаа хийгээд өнгөрөх бус, харин судалгаанд тулгуурлан бодлого, төлөвлөгөө боловсруулж, тууштай, тогтвортой хэрэгжүүлж байж үр дүнд хүрнэ. Жендэрийн тэгш байдлыг хангах дараах үндсэн дөрвөн үе шат бий. Үүнд:

- Байгууллага дахь жендэрийн нөхцөл байдлыг тандан судлах;
- Байгууллагад жендэрийн талаар тавих зорилго, хүрэх арга замыг тодорхойлон төлөвлөгөө гаргах;
- Жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг үнэлгээ хийж, дараагийн шатны төлөвлөлт хийх.

Дээрх дөрвөн үе шатанд хийх ажлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараах зөвлөмжүүдээс үзнэ үү. Хэрэв та энэ сэдвээр гүнзгийрүүлэн судлах хүсэлтэй байгаа бол “Хувийн хэвшлийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх зөвлөмж” (Жендэрийн үндэсний хороо, 2019) гарын авлага болон бусад хэрэгцээт материалыг Жендэрийн үндэсний хорооны www.ncge.gov.mn цахим хуудаснаас татан авах боломжтой.

Редакцын үйл ажиллагаан дахь жендэрийн тэгш байдлыг дэмжих тусгайлсан зөвлөмжүүд:

- Байгууллагын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтнүүд жендэрийн талаар илүү мэдлэг, санаачилгатай байх нь чухал. Тэд дотоод дүрэм журам болон хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох боломжтой. Мөн жендэрийн асуудал хариуцсан ажилтныг томилж, ажил үүргийн хуваарьт нь хийх ажлын чиг үүргийг тусгаж, жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөөтэй байж, хэрэгжилтийг хянана.
- Жендэрийн асуудлаар ямар нэгэн шийдвэр гаргах, тухайлбал төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхдээ ажилтнуудыг оролцуулж, шинэ хандлага, соёлыг нэвтрүүлэх нь чухал. Үүний тулд байгууллагын дотоод журамд хамт олны хурал, олонхийн саналаар шийдвэрлэх асуудлын чиглэл, хүрээг тодорхойлох, бодлогын болон байгууллагын санхүүгийн асуудлыг боломжит түвшинд оруулах хэрэгтэй. Мөн төлөвлөгөө боловсруулах ажлыг жендэрийн тэнцвэртэй байдлыг хангасан багт даалгах зэрэг аргыг туршин нэвтрүүлж болно.
- Хүний нөөц болон шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь редакцын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгоход эергээр нөлөөлдөг. Салбар, алба тус бүрд ажилтнуудын тоог нас, хүйс, албан тушаалаар ангилсан эсэхийг шалгаарай. Мөн ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаанд жендэрийн асуудлыг тусгаж, тулгамдсан асуудлыг илрүүлэх хэрэгтэй. Эдгээр мэдээлэлд тулгуурлан жендэрийн дүн шинжилгээ хийнэ.
- Хүний эрх, жендэрийн тэгш эрхийн талаарх ажилтнуудынхаа мэдлэгийг сайжруулах сургалт зохион байгуулах. Ингэхдээ бэлэн байгаа сургалтын модуль, сургагч багшид зориулсан гарын авлага зэргийг ашиглаж болно. Эсвэл сэтгүүлч, редакторуудаа энэ чиглэлийн сургалтад хамруулж, тэдгээр ажилтан сурч мэдсэнээ хамт олондоо заах нөхцөлийг бүрдүүлээрэй.
- Хөдөлмөрийн аюулгүй орчин бий болгох. Ялангуяа ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, энэ талаарх гомдлыг хүлээн авч, барагдуулах, бэлгийн дарамтад өртсөн ажилтнуудад дэмжлэг, туслалцаа үзүүлж, нэр төрийг нь сэргээх журам, тогтолцоотой болох. “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргагүйн зөвлөмж”¹-ийг ашиглах боломжтой.
- Ажилтан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд нууцлалыг хэрхэн хамгаалж, ямар тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх. Энэ талаар ажиллагсдад сургалт явуулах.
- Сэтгүүлч, сурвалжлагч дарамт шахалт, үзэн ядалт, гутаан доромжлолд өртсөн тохиолдолд дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгтэй. “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого”² зөвлөмжид энэ талаар тусгасан.
- Цалин, хөлс, шагнал урамшуулал, албан тушаал, ажлын томилгоонд тэгш байдлыг хангах.
- Ажил, хувийн амьдралын тэнцвэртэй байдлыг хангах бодлоготой байх. Жирэмсний болон амаржсаны чөлөө/эцгийн чөлөө, хүүхэд асрах чөлөөг хуулийн дагуу өгөхөөс гадна гэр бүлтэй, хүүхэдтэй ажилтнуудыг дэмжих хөдөлмөрийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.
- Мөн редакцын үйл ажиллагаанд ашигладаг хяналт үнэлгээний хуудас, судалгаа шинжилгээнд жендэрийн тэгш байдлыг хангасан эсэхийг хэмжих үзүүлэлт, агуулга, сэдвийг тусгаж ашиглаарай.

Редакцын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах ажлын төлөвлөгөө нь гарааны алхам гэдгийг санаарай. Цаашид редакцын улирал, жилийн ажлын төлөвлөгөө, олон жилийн стратеги төлөвлөгөөнд жендэрийн асуудлыг тусгах хэрэгтэй. Энэ хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмжих арга хэмжээ тусгаж болно. Үндэсний болон орон нутаг, салбарын түвшинд байгууллагуудын жендэрийн чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах, мэдээлэх боломжтой бөгөөд энэ нь нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй редакцын нэгэн үзүүлэлт болно.

¹ Жендэрийн үндэсний хорооны <https://www.ncge.gov.mn/publications> цахим хуудаснаас pdf хувилбарыг татаж авах боломжтой.

² Хэвлэл мэдээллийн зөвлөлийн <https://www.mediacouncil.mn> цахим хуудасны “Тайлан” хэсгээс pdf хувилбарыг татаж аваарай.

Хоёрдугаар бүлэг.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ


Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төслийн судалгаанаас үзэхэд мэдээний агуулга дахь эх сурвалжуудын 25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Үүнийг задалж үзвэл гоо сайхан болон загварын ертөнц, гэр бүл хүүхэд хамгаалал, нөхөн үржихүйн сэдвээр гарсан мэдээний эх сурвалжуудын 60 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол улс төр, эдийн засаг, спортын мэдээнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш бага байна (GMMP, 2020).

Энэтхэг, Кени, Нигер, Өмнөд Африк, Их Британи болон АНУ гэсэн зургаан улсын англи хэл дээрх хэвлэл мэдээллийн агуулгад таван сарын турш мониторинг хийсэн “Мэдээнд үгүйлэгдсэн эмэгтэйчүүдийн байр суурь” судалгаанаас харахад эмэгтэйчүүд хэвлэл мэдээллийн агуулгаас орхигдсон хэвээр байна. Тухайлбал, 2019 онд Их Британий цахим мэдээний эх сурвалжуудын 29 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлсэн нь дээрх зургаан улс

дотор хамгийн өндөр үзүүлэлт байсан бол Энэтхэгт энэ үзүүлэлт ердөө 14 хувь байв. Эдийн засгийн салбарт эрэгтэйчүүдийн дуу хоолой эмэгтэйчүүдийнхээс бүр 31 дахин их байсныг уг судалгаанд онцолжээ (Kassova, 2020).

Монгол Улсад хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны тайлангаас үзэхэд мэдээллийн хоёр сайтын эх сурвалжуудын 77 хувь нь эрэгтэй, 23 хувь нь эмэгтэй, өдөр тутмын сонины эх сурвалжуудын 26 хувь, телевизүүдийн 29 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, зөвхөн MYONP болон Гэр бүлийн радиогийн агуулга дахь эх сурвалжуудын 48 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн эрэгтэйчүүдийг ихэвчлэн ажил хэрэгч, албан тушаалтан, улстөрч дүрээр, харин эмэгтэйчүүдийг албаны бус зургаар, энгийн иргэн, ээж, гэргий, эсвэл мэргэжилтнээр илүүтэй дүрсэлдгийг уг судалгаанд онцолсон байна (Хэвлэлийн хүрээлэн, 2017).

МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖУУДАД ЭЗЛЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХУВЬ



Эх сурвалж: Хэвлэлийн хүрээлэн, 2017

Хэвлэл мэдээллийн агуулга дахь жендерийн энэхүү тэгш бус байдал болон хэвшмэл ойлголтыг дэвэргэх хандлага нь эмэгтэйчүүдийн эрхийг тодорхой хэмжээгээр хааж байгаа юм. Тухайлбал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хэвлэл мэдээллийн салбар дэмжихгүй байна. 2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэйчүүд байсан бол сонгуулийн сурталчилгааны үеийн нийт контентын 14 хувь нь л эмэгтэй нэр дэвшигчдийг дурджээ. (Хэвлэлийн Хүрээлэн, 2016).

Монголын хэвлэл мэдээллийн салбарт эмэгтэйчүүд давамгайлж байгаа ч сэтгүүл зүйн агуулгад эмэгтэйчүүдийн дуу хоолойг тэнцвэртэй хүргэх, жендерийн хэвшмэл ойлголтуудыг халах тал дээр учир дутагдалтай байгааг дээрх тоо баримтууд илтгэж байна. Үүнийг залруулахын тулд олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын туршлагыг судалцгаая.

Чиг хандлага:

Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах

Хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдлыг хангах нь өргөн хүрээтэй үйл явц боловч хамгийн энгийн арга бол эх сурвалжид жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах явдал юм. Сэтгүүл зүйн мэдээ, бүтээлүүд эмэгтэйчүүдийн төлөөллийг багтаах тал дээр учир дутагдалтай байдаг нь цаанаа олон шалтгаантай. Нэг талаас сэтгүүлчид жендэрийн тэгш байдлын талаар хангалттай ойлголтгүйгээс болж нэг тал руу хэлбийх, цаг хугацаа давчуу байх, эмэгтэй эх сурвалжууд олдоц муутай байх зэрэг бэрхшээлтэй тулгардаг бол нөгөө талд эмэгтэйчүүд хэвлэл мэдээлэлтэй харилцах туршлага, мэдлэг хомс, мөн цахим дарамт, доромжлолд өртөх магадлал их тул хэвлэл мэдээллээс зайлсхийдэг (Internews, United for News).

Иймд мэдээний агуулгадаа эмэгтэйчүүдийн олон талт төлөөллийг эх сурвалж болгон оруулахын тулд редакц, сэтгүүлчид арга барилаа өөрчлөх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд олон улсын томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ чиглэлээр амжилтад хүрч, бусад нь үлгэр дуурайл авч байна.

Тухайлбал, Лондон дахь BBC-гийн редакц мэдээн дэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэхийн тулд 2017 оноос эх сурвалжийн мониторинг хийж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах “50:50” санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоо дэлхий даяар 670 салбар хэлтэс нь энэ санаачилгад нэгдэж, тэдний 70 гаруй хувь нь мэдээний эх сурвалжийнхаа тал хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлэх зорилгодоо хэдийнэ хүрчээ. BBC одоо энэ аргаа ашиглан үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг нэмэгдүүлэхээр ажиллаж эхлээд байна (50:50 The Equality Project, 2021).

Австралийн ABC бас ижил зорилго тавьж, хоёр жил тууштай ажиллан 2021 оны гуравдугаар сард мэдээний эх сурвалжаар эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тоог тэнцүүлж чадсан байна. “Wall Street Journal”, “Financial Times” зэрэг сонины удирдлага ч мөн агуулга дахь жендэрийн тэгш бус байдлыг устгахаар 2017 оноос ажиллаж байна.

Олон улсын хэвлэл мэдээллийн томоохон байгууллагууд мэдээнийхээ агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах хандлагатай болж, зарим нь амжилтад хүрч шинэ үзэгч, уншигчдаар хүрээгээ тэлж байна. Тухайлбал, “Financial Times” сонины захиалагчдын 80 хувь нь эрэгтэйчүүд байсан бол эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн агуулга бэлтгэж, мэдээ гаргаж эхэлснээр эмэгтэй захиалагчдын тоо өсжээ. Мөн BBC онлайн хэрэгчлэгчдийнхээ дунд санал асуулга явуулахад олонх нь агуулга дахь эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнийг анзаарсан гэж хариулсан бөгөөд 16-34 насны эмэгтэйчүүдийн ихэнх нь үүнд татагдаж, BBC-ийн контентыг түлхүү хэрэглэдэг болсон гэжээ (50:50 The Equality Project, 2021).

Иймд эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд редакцууд

1. Төлөвлөж судлах,
2. Бүртгэл хөтлөх,
3. Редакцын ажилтнуудын оролцоог хангах,
4. Эх сурвалжуудаа чадавхжуулах гэсэн

дөрвөн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хэрэгтэй гэж “Бодит байдлыг тусга” гарын авлагад зөвлөсөн. Энэ зөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлснийг “Bloomberg”-ийн туршлагаас харна уу.

Тэргүүн туршлага:**“Bloomberg”-ийн “New Voices” санаачилга**

Сэтгүүл зүйн үнэн зөв, бодитой байх, тэнцвэртэй байдлыг хадгалах зарчмыг чандлан сахих, мөн ажиллах хүчин болон агуулгаа төрөлжүүлэх томоохон зорилгынхоо хүрээнд “Bloomberg” 2018 оны эхээр “New Voices” санаачилгаа зарласан. Үүний үр дүнд телевизийн шинжээч эх сурвалжуудын 10 хувийг бүрдүүлж байсан эмэгтэйчүүдийн тоон үзүүлэлтийг бараг гурав дахин нэмэгдүүлжээ.

Төлөвлөж судлах: “Bloomberg” 2017 онд агуулгадаа судалгаа хийхэд редакцын зочноор ирж ярилцлага өгсөн шинжээч эх сурвалжуудын ердөө 10 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байжээ. Иймд “Bloomberg” үүнийг өөрчилж, агуулга дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөгөө гаргаж, 2018 оны эхэнд “New Voices” санаачилгаа олон нийтэд танилцуулсан байна.

Бүртгэл хөтлөх: “Bloomberg” онлайн, хэвлэл, телевиз, радио, фото зураг, шууд нэвтрүүлэг зэрэг бүх платформынхоо агуулга дахь олон талт байдлыг хянаж, мониторинг хийж, мэдээний программ хангамжаа шинэчилж, эмэгтэйчүүдийг эш татсан мэдээ бүрийг бүртгэдэг болжээ.

Редакцын ажилтнуудын оролцоог хангах: Эмэгтэй эх сурвалжийн тоог нэмэгдүүлэхэд сэтгүүлчид багагүй бэрхшээлтэй тулгарав. Эдийн засаг, бизнес, улс төр, технологийн чиглэлээр ярих эмэгтэй шинжээч олддохгүй; олдсон ч зурагтаар гарахаас зайлсхийж, эмээж байв. Үүнийг шийдэхийн тулд “Bloomberg”-ийн сэтгүүлчид олон улсын дата бааз бүрдүүлж, эмэгтэй эх сурвалжийн жагсаалтыг 500-гаас 5000 гаруй болгон өсгөж, хэвлэл мэдээлэлтэй харилцахаас эмээдэг эмэгтэйчүүдэд зориулж сургалтын хөтөлбөр боловсруулсан байна.

Эх сурвалжаа чадавхжуулах: “Bloomberg” болон бусад хэвлэл мэдээллээр гарах эмэгтэй эх сурвалжийн тоог өсгөхийн тулд бизнес, санхүүгийн салбарын удирдах албан тушаалтан эмэгтэйчүүдэд зориулж дөрвөн цагийн сургалт зохион байгуулж эхэлжээ. Энэ сургалтад гурван жилийн дотор 250 гаруй эмэгтэй хамрагдсан байна.

Эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр өгөх зөвлөмжүүд:

- Редакцынхаа бэлтгэж байгаа мэдээ, нэвтрүүлгийн эх сурвалжуудын хэдэн хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбар бүрээр ангилж гаргаарай. Ингэснээр та бүхэн жендэрийн тэнцвэртэй байдлыг агуулгадаа хэр хангаж байгаагаа олж мэднэ.
- Мэдээн дэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх **бодитой, хэмжиж, хэрэгжүүлж болохуйц** зорилго тавих. Тухайлбал, Монголд магистрантур, докторантурт сурч буй хүмүүсийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Иймд мэдээгээр гарч байгаа шинжээчдийн дор хаяж 50 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлэх нь зохистой. Харин УИХ-ын гишүүдийн 20 хүрэхгүй хувь нь эмэгтэйчүүд тул УИХ-ын эх сурвалжуудын 20 орчим хувь нь эмэгтэйчүүд байж болно.
- Зорилгодоо хүрэх шат дараалсан төлөвлөгөө гаргаарай. Тухайлбал, эмэгтэй эх сурвалжуудын эзлэх хувийг эхний жилд 40, дараагийн жилд 50 хувьд хүргэх гэх мэт. Хамгийн гол нь ахиц гарсан эсэхээ хэмжиж болохуйц зорилт тавих шаардлагатай.
- Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоо нийтлэлийн бодлого, мэдээ, сурвалжлагад тавих шаардлагад тусгана.
- Агуулга дахь жендэрийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд эх сурвалжуудаа хүйсээр ангилдаг мониторингийн аргыг ашиглах нь хамгийн үр дүнтэй. BBC-гийн "50:50" төслийн мониторингийн аргыг ашиглах боломжтой. Дэлхийн 26 орны 100 гаруй байгууллага энэ аргыг ашиглаж байна³.
- Санаачилгадаа олны анхаарал татахуйц нэр өгснөөр редакцын ажилтнууд төдийгүй бусад байгууллага, уншигч үзэгчдийн дэмжлэгийг авах боломжтой. Тухайлбал "Bloomberg" санаачилгаа "New voices", BBC "50:50" гэж нэрлэн олны анхаарлыг татаж, уриалга гаргаж байв.
- Ажилтнуудыг бүгдийг нь санаачилгад оролцуулахын тулд редакцын уулзалтыг тогтмол зохион байгуулж, гарч буй ахиц дэвшлээ тэмдэглэж, хүрэх зорилгоо сануулж, тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, нөөц хэрэглэгдэхүүнийг хэлэлцэж, туршлага судлах боломжийг бүрдүүлэх нь чухал. Редакцын бүх ажилтан, ялангуяа эрэгтэйчүүдийг санаачилгадаа оролцуулаарай.
- Эмэгтэй эх сурвалжуудтай холбоо барих жагсаалт буюу дата бааз бий болгох. Энэ аргыг "Bloomberg" төдийгүй Скандинавын орнуудын редакцууд хэрэглэж, өндөр үр дүнд хүрсэн.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, эх сурвалжийн жагсаалтаа тогтмол шинэчлэх. Тэдэнд өөрсдийн санаачилга, зорилгоо танилцуулж, тухайн салбарт эмэгтэй эх сурвалжуудын дуу хоолой сул байгааг мэдэгдээрэй. Энэ талаар "Bloomberg" эрчим хүчний салбар дахь эмэгтэй захирлуудын "Haw- thorne Club"-тай, "Toronto Star" сонин эмэгтэй зохион бүтээгчид, бизнес эрхлэгчдийг дэмжих "She Innovates Alberta" байгууллагатай хамтран ажилласан байна.
- Төрийн байгууллага, мэргэжлийн холбоодын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтнүүдтэй ажиллаж, байнга яриа өгдөг эрэгтэй эх сурвалж биш, харин тухайн сэдэв, асуудлыг маш сайн мэдэх эмэгтэй эх сурвалжуудтай танилцуулахыг хүсээрэй.
- Эх сурвалж болсон эмэгтэйчүүдийг цахим орчинд гутаах, доромжлох тохиолдол түгээмэл байдаг. Иймд мэдээний сэтгэгдлийг хаалгах эмэгтэй эх сурвалжийн хүсэлтэд редакц уян хатан хандаж, хүсэлтийг нь хүлээн авч, хэрэгжүүлдэг зохицуулалттай болох хэрэгтэй.

³ "50:50" төслийн аргачлал, түүнийг хэрхэн ашиглах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.bbc.co.uk/5050/partners/home> цахим хуудаснаас авна уу.

Мэдээний эх сурвалжид эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх олон улсын туршлагыг нэвтрүүлэхийн зэрэгцээ жендэрийн ялгаатай байдал нь зөвхөн хүйс бус, нас, газарзүйн байршил, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон үзүүлэлттэй уялдаатай болохыг анхаарч, мэдээний агуулгад нийцүүлэн эрэгтэй, эмэгтэй эх сурвалжуудыг сонгохдоо хот, хөдөөгийн, гэрлэсэн, ганц бие зэрэг янз бүрийн насны иргэдийн төлөөллийг бүрэн хамруулахыг хичээгээрэй. Мөн Монгол Улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9.7 жилээр богино, дээд боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээс цөөн байгаа зэрэг жендэрийн ялгаатай байдлыг харгалзаж үзэх шаардлагатай.

Шинэ өнцөг:

Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах

Нийгэмд бугшсан хэвшмэл ойлголтуудыг дэвэргэхээс зайлсхийх төдийгүй өөрчилж, халахад хувь нэмэр оруулах нь сэтгүүлч хүний үүрэг. Ингэхдээ жендэрийн хэвшмэл ойлголтыг халж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд төдийгүй ЛГБТИК⁴ хүмүүсийн дүр төрхийг үнэн, бодит байдалд нийцүүлэн илэрхийлэх нь чухал.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн онцлог шинж, чадвар туршлага, хүсэл сонирхол зэрэгтэй холбоотой нийтлэг хүлээлтийг эвдэхүйц сэтгүүл зүйн бүтээлийг хэвшмэл ойлголтыг халсан гэж тодорхойлж байна. Тухайлбал, санхүү, эдийн засгийн бодлогын талаар эмэгтэй экспертүүд түлхүү оролцсон хэлэлцүүлэг, эсвэл эрэгтэй сувилагч нарын тухай өгүүллийг энд дурдаж болно. Зарим бүтээлээр нийгэмд байгаа жендэрийн хэвшмэл ойлголтыг илүү даацтайгаар задлан шинжилж халахыг хичээж болдог. Жишээ нь, сонгуулийн талаарх мэдээ, нэвтрүүлгээр эмэгтэйчүүд улс төрийн идэвх муутай байдаг гэсэн хэвшмэл ойлголтыг эвдэж болно. Хэвшмэл ойлголтуудыг халсан сэтгүүл зүйн бүтээл нь аливаа асуудлыг тэс өөр өнцөг, байр сууринаас тайлбарлаж, шинэ арга зам нээдгийг Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн аргачлалын зааварт онцолжээ (GMMP Methodology Guide, 2020). Гэвч мониторингийн дүнгээс харахад нийт мэдээний ердөө дөрвөн хувь нь л жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн байна.

ЖЕНДЭРИЙН
ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫГ
ХАЛЖ, ЭМЭГТЭЙЧҮҮД,
ЭРЭГТЭЙЧҮҮД
ТӨДИЙГҮЙ ЛГБТИК
ХҮМҮҮСИЙН ДҮР
ТӨРХИЙГ ҮНЭН,
БОДИТ БАЙДАЛД
НИЙЦҮҮЛЭН
ИЛЭРХИЙЛЭХ НЬ
ЧУХАЛ.

⁴ Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйр гэсэн үгсийн товчлол. Бэлгийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа ЛГБТИК нь зөв хэрэглээ болдог.

Сэтгүүл зүйн бүтээлээрээ жендэрийн хэвшмэл ойлголтыг халах чиглэлээр өгөх зөвлөмжүүд:

- Эмэгтэй, эрэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурь, үүрэг хариуцлагыг хүйсээр илтэд ялгаварласан байдлаар тайлбарлахаас зайлсхийгээрэй. Тухайлбал, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлаар эмэгтэй гишүүд анхаарахгүй байна гэж шүүмжлэх нь зохисгүй. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад эрэгтэй гишүүд ч бас оролцох ёстой.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийг “эмэгтэйлэг” эсвэл “эрэгтэйлэг” хэвшсэн шинжээр дүрслэн харуулж, үүнийг хэвийн, хувиршгүй үзэгдэл гэх ойлголт төрүүлэхээс зайлсхийгээрэй. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм дэх бусад боломжит шинж чанар, үүрэг хариуцлагыг үгүйсгэх хандлагыг бий болгодог. Тухайлбал, эрэгтэй хүнийг боловсрол, ажил мэргэжлийн амжилтаар нь, эмэгтэй хүнийг царай зүс, бие галбир, өмссөн зүүснээр нь, эсвэл хэр сайн гэрийн эзэгтэй вэ гэдгээр нь сонжих хандлага ажиглагдсаар байна. Бизнес эрхлэгч, эсвэл улстөрч эмэгтэйн талаар нийтлэл/нэвтрүүлэг бэлтгэхдээ хэдэн хүүхэдтэй, хэр сайн ээж вэ гэдгийг зайлшгүй шаардлагатай биш бол оруулах хэрэггүй.
- Ашиглаж байгаа тэмдэг нэрээ анхаараарай. Тухайлбал, охид, эмэгтэйчүүдийг уян зөөлөн, сайхан сэтгэлтэй, хөдөлмөрч, харин хөвгүүд, эрэгтэйчүүдийг зоригтой, шийдэмгий, ажил хэрэгч, гүндүүгүй; эмэгтэйчүүдийг идэвхгүй, эрэгтэйчүүдийг идэвхтэй хэлбэрээр байнга дүрслэхээс зайлсхийгээрэй.
- Зураг дүрсээ мөн анхаараарай. Эрэгтэйчүүдийг ажил хэрэгч байдлаар, ихэвчлэн албан тушаалтан, улстөрч дүрээр, харин эмэгтэйчүүдийг албаны бус зургаар, ихэвчлэн энгийн иргэн, мэргэжилтэн, ээж, гэргийн дүрээр гаргах нь бодит байдалтай тэр бүр нийцэхгүйг анхаараарай.
- Аливаа үйл явдал, сэдэвт эрэгтэй/эмэгтэйчүүдийн оролцоог үнэн бодитоор, цогцоор нь тусгахад анхаарах шаардлагатай. Тухайлбал, цэцэрлэг, сургуульд хүүхдээ хүргэж өгч, авч байгаа аавууд Монголд маш олон бий. Гэтэл энэ сэдвээр эцэг эхийг төлөөлж ихэвчлэн эмэгтэйчүүд мэдээгээр гардаг.
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн олон хэмжээст төлөөлөл/дүр төрхийг харуулахуйц эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг мэдээний эх сурвалжаар сонгох нь чухал. Зарим сэдвээр эмэгтэйчүүд, эсвэл эрэгтэйчүүд огт үзэгддэггүй. Тухайлбал, хүчирхийлэл, гэмт хэрэг, ядуурлын сэдвээр дандаа эмэгтэй хохирогч гардаг. Хүчирхийлэлд өртсөн эрэгтэйчүүд хэдий цөөн ч тэдний дуу хоолойг огт гаргахгүй байх нь үнэнд нийцэхгүй.
- Зар сурталчилгаагаа ч мөн жендэрийн хэвшмэл ойлголтыг халсан байдлаар гаргахыг хичээгээрэй. Тухайлбал, хоол хийх, гэр цэвэрлэх, хүүхэд арчилгаатай холбоотой бүтээгдэхүүнийг сурталчлахдаа эрэгтэйчүүдийг оролцуулах.

Жендэрийн тэгш байдлыг хангах тал дээр “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэх

“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан нь жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчны үндэс суурь болдог. Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд болон олон улсын байгууллагууд жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоо бий болгон бэхжүүлэх чиглэлээр сүүлийн 20 гаруй жилд хүчин чармайлт гаргаж ирсэн. Энэ бүх хүчин чармайлтын үр дүнг нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн тэгш байдалд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн салбар онцгой үүрэг гүйцэтгэнэ. Учир нь, жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн талаарх мэдээ, сурвалжлга нь хэвлэл мэдээллийн гүйцэтгэдэг нийгмийн “хоточ нохойн” үүргийн салшгүй, чухал хэсэг юм.

Цаг үеийн тулгамдаж байгаа жендэрийн асуудлыг сайтар судалж, тэдгээрийг шийдэхэд дэмжлэг болохуйц чухал ач холбогдолтой агуулга бүтээхэд жендэрийн линз ашиглах нь зүйтэй. Жендэрийн линзний тусламжтайгаар аливаа үйл явдал, эсвэл асуудал эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, охид хөвгүүдэд хэрхэн өөр өөрөөр нөлөөлж байгааг болон тэд хэрхэн өөр өөрөөр хүлээн авч байгааг харж болдог. Ингэснээр бүтээлээ жендэрийн өнцгөөс, илүү сонирхолтой, чухал талыг нь тодотгон туурвих боломжтой болно. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээлээд өнгөрдгөөс илүү өргөн цар хүрээг хамарч, илүү гүн гүнзгий судалж гаргах давуу талтай. Үүний тулд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал юм.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан чиглүүлдэг. Яам бүрд Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан жендэрийн салбар зөвлөл, 21 аймаг, нийслэл болон Нийслэлийн есөн дүүргийн Засаг даргаар ахлуулсан жендэрийн салбар хороо ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооны дэргэд үндэсний шинжээчдийн бүлэг, эрдэмтэн судлаачдын бүлэг, хэвлэл мэдээллийн зөвлөл ажилладаг учраас хамтран ажиллах боломжтой.

Жендэрийн тэгш/тэгш бус байдлын талаар мэдээлэх чиглэлээр өгөх зөвлөмжүүд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тал дээр ямар алдаа дутагдал байгааг судалж гаргах нь маш чухал. Үүний тулд тухайн сэдвийг сайн мэдэх мэргэжилтнүүдээс заавал зөвлөгөө аваарай.
- Статистик, дата мэдээллийг үргэлж нас, хүйсийн задаргаатай нь харж хэвшээрэй. Ингэснээр ямар ч асуудлыг илүү сонирхолтой өнцгөөс барьж авч болно. Жендэрийн статистикийг ашигладаг дадал хэвшлийг бий болгох нь зүйтэй.
- Хүйсийн ялгаатай байдлыг бий болгож буй улс төр, эдийн засаг, нийгэм соёлын нөхцөл байдал, хүчин зүйлүүдийн талаар судалж, тоон болон чанарын мэдээллүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийх нь чухал.
- Олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг илүү их татаж, илүү нөлөө үзүүлэхийн тулд редакцияас төлөвлөсөн тусгай эрэн сурвалжилга, дата сэтгүүл зүйн бүтээл зэргийг гаргаж болно. Ийм нийтлэл, нэвтрүүлгээ аль болох оргил цаг/эхний нүүр зэрэгт онцгойлон гаргахад анхаараарай.
- Жендэрийн тэгш байдал болон жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар нийтлэл мэдээлэл бэлтгэхэд бодит хүний түүх (human interest story), амжилт, бэрхшээл, сургамж дээр тулгуурласан мэдээлэл хүмүүст илүү хүрдэг болохыг олон улсын туршлага харуулж байна. Агуулгаа бэлтгэхдээ жендэрийн тэгш бус байдлын суурь шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлүүд, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний давуу болон сул талуудын талаар ул суурьтай судалж гаргах нь зүйтэй.
- Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагууд шилдэг бүтээл шалгаруулах уралдаан, тэтгэлэг зэргийг элбэг зохион байгуулах болсон. Ийм боломжуудын талаар мэдээлэлтэй байж, сэтгүүлчдээ оролцохыг дэмжиж байгаарай.

Гуравдугаар бүлэг.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУРВАЛЖЛАХ НЬ

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь ихэнхдээ далд, нууц хэлбэрээр оршин тогтнож байдаг. Нийгэмд түгээмэл ажиглагддаг хохирогчийг буруутгах хандлагаас болж энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн, хохирсон хүмүүс хуулийн байгууллагад хандахгүй байх, эрүүл мэндийн болон сэтгэл заслын зохих үйлчилгээ авч чадахгүй үлдэх нь элбэг. Мөн айдас, түгшүүр, бусдын зүгээс үзүүлэх дарамт, заналхийлэл зэрэг олон шалтгааны улмаас даван туулагчид ил гарах, хэвлэл мэдээллийнхэнд хандахаас зайлсхийдэг. Сэтгүүлчид болон редакторууд ч ийм сэдвийг аль болох тойрч гарахыг хичээж ирсэн нь нууц биш.

Гэтэл жендэрт суурилсан хүчирхийлэл нь нийгэмд тулгамдсан асар том асуудал болчихоод байгааг мэргэжлийн байгууллагуудын хийсэн олон судалгаа харуулж байна. Тийм ч учраас хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид эдгээр асуудлыг ул суурьтай судалж, зөв өнцгөөс хөндөж олон нийтэд хүргэх нь чухал. Сүүлийн таван жилийн хугацаанд энэ тал дээр нэлээд ахиц дэвшил гарсныг тэмдэглүүштэй.

2017 онд “The New York Times”, “The New York- er”, “The Washington Post” сонин кино ертөнц болон улс төрийн нөлөө бүхий хүмүүсийн бэлгийн дарамт, хүчирхийллийн асуудлыг эрэн сурвалжилж гаргасан. Тэдгээр бүтээл хэд хэдэн Пулицерийн шагнал аваад зогсохгүй дэлхий даяар хэвлэл мэдээллийн салбарынхан энэ сэдвийг өөр өнцгөөс харах боломж олгосон юм. 2017 оны арванхоёрдугаар сард “Time” сэтгүүл оны хүний нүүр хуудсандаа “Аниргүйг эвдэгсэд” хэмээн ажлын байрны бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн тухайгаа олон нийтэд зориглон ярьсан эмэгтэйчүүдийг онцолсон. Цөөн хүний зориг гарган эхлүүлсэн энэ ажил төд удалгүй олон улсын хөдөлгөөн болж, #MeToo хаштагтайгаар сая сая эмэгтэйчүүд хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэсэн билээ.

Гэвч жендэрт суурилсан хүчирхийлэл нь далд, нууц хэлбэрт байдгаас гадна маш эмзэг сэдэв учраас мэргэжлийн, туршлагатай сэтгүүлч хүртэл алдаа гаргах, улмаар даван туулагч, түүний үр хүүхдүүдийн амьдрал, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах тохиолдол бий. Мөн “Copy-cat effect” буюу сэдэл төрүүлэх нөлөө үзүүлэх эрсдэл ч энэ сэдвийг байнга дагалдаж байдаг. Хүчирхийлэл, амиа хорлолтын аймшигт хэргүүдийг дуулиан шуугиан болгон мэдээлснээр тийм арга замаар үйлдсэн хэргийн тоо өсөж байгааг баримтжуулсан судалгаанууд ч байна.

Иймд, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөх нь сэтгүүлчээс ёс зүйн сахилга бат, мэдрэмж, судалгаа хийх мэргэжлийн ур чадвар, ярилцлага хийх тусгай арга барил болон энэ төрлийн гэмт хэрэг, хууль эрх зүйн орчны талаарх мэдлэг, боловсрол зэргийг цогцоор нь шаарддаг. Энэ бүхнийг цогцлоон бүрдүүлэхэд туслах зөвлөмжийг дараах сурах бичиг, гарын авлагуудад тулгуурлан боловсрууллаа:

-“Хохирогч төвтэй мэдээлэл: АББД, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийг эрэн сурвалжлах нь” (Хүйсийн тэгш эрхийн төв, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, 2018);

-“Жендэрт суурилсан хүчирхийллийг сурвалжлах нь” (Sonke Gender Justice and Health-E News, 2017);

-“Зөв үг ашигла: Канад дахь бэлгийн хүчирхийллийг хэвлэл мэдээллээр сурвалжлах нь” (FEMIFESTO, 2015) гарын авлага;

-“Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг сурвалжлах нь” (UNESCO, 2019) сэтгүүлчдэд зориулсан гарын авлага.

**Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх
хэвшсэн буруу ойлголт, хандлага**

ХУДАЛ	ҮНЭН
Эмэгтэй хүн “үгүй” гэвэл “тийм” гэсэн үг.	“Үгүй” гэвэл “үгүй” л гэсэн үг!
Бэлгийн хүчирхийллийг үргэлж танихгүй хүн үйлддэг бөгөөд харанхуй шөнө гадуур ганцаараа явахад тохиолддог.	Судалгаанаас үзэхэд дөрвөн хохирогч тутмын гурвыг ямар нэг байдлаар таньж мэддэг хүн нь хүчирхийлсэн байна (Хүйсийн тэгш эрхийн төв, 2018).
Найз залуу, эсвэл нөхөртөө хүчиндүүлнэ гэсэн ойлголт байхгүй. Өмнө нь дотно харилцаатай байсан бол тэр хүчингийн хэрэг биш.	Хүч хэрэглэн, айлган сүрдүүлж бэлгийн харьцаанд оруулах нь хүчингийн хэрэг мөн. Үүнд гэр бүл болсон, эсвэл өмнө нь бэлгийн харьцаанд орж байсан эсэх хамаагүй.
Бэлгийн хүчирхийлэлд зөвхөн эмэгтэйчүүд өртдөг.	Бэлгийн хүчирхийлэлд хэн ч өртөж болно. Эрэгтэйчүүд, ЛГБТИК хүмүүс ч хохирогч болдог.
Хэт ил задгай хувцас өмссөнөөсөө болж л бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог.	Юу өмсөж, яаж харагдах нь хүчирхийлэлд өртөхөд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Манцуйтай хүүхдээс эхлээд тэргэнцэртэй настай хүн хүртэл бэлгийн хүчирхийлэлд өртөх тохиолдол гардаг. Хүчин гэдэг бол зөвхөн хүчирхийлэгчийн буруу!
Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч нь өөрөө тийм байдлыг бий болгодог. Хэрвээ хүсвэл нөхөр, найз залуугаасаа салж болох л байсан.	Хохирогч хүчирхийлэгчээс хамааралтай байх тохиолдол элбэг бөгөөд ичиж зовох, өөрийгөө буруутгах, бие даан амьдрах чадваргүй байх, дарамт, сүрдүүлгээс айх зэрэг олон шалтгааны улмаас харилцаагаа тасалж чаддаггүй.
Жендэрт суурилсан хүчирхийлэлд зөвхөн ядуу, ажилгүй эмэгтэй өртдөг.	Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн хувьд нас, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, байршилын онцлог ялгаа ажиглагдахгүй байгааг судалгаа харуулсан (Үндэсний статистикийн хороо, 2018).
Эрэгтэйчүүд бэлгийн дур хүслээ дарж чадахгүй болохоор л хүчирхийлэл үйлддэг.	Хүчирхийлэгч өөрийн эрх мэдэл хүчний давуу байдлаа ашиглан хэн нэгнийг хүсэл зоригийнх нь эсрэг хүчирхийлдэг (Жендэрийн үндэсний хороо, 2018).
Хүчирхийлэл үйлдэгчид сэтгэцийн өвчтэй, аймшигт араатнууд байдаг.	Ямар ч хүн хүчирхийлэгч байж болно. Гэр бүлийн гишүүнээс эхлээд олны танил, нэр хүндтэй хүн ч хүчирхийлэл үйлддэг

Хохирогчийг буруутгах хандлага гэж юу вэ?

Аливаа осол, гэмт хэргийн хохирогчийг болсон явдалд бүрэн, эсвэл тодорхой хэмжээгээр буруутгахыг хохирогчийг буруутгах хандлага гэдэг (The Canadian Resource Centre for Victims of Crime, 2009). Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүнийг амьдралын хэв маяг, хувцаслалт, биеэ авч явах байдал, үйлдэл зэргээр нь буруутгах хандлага нийгэмд түгээмэл. Гэтэл амьдралын хэв маяг ямар байхаас үл шалтгаалан хүчирхийлэлд хэн ч өртөж болно.

Сэтгүүлч хүн жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлын талаар бичихдээ хохирогчийг буруутгах сэдэл төрүүлэхүйц мэдээлэл өгөхгүй байх нь чухал. Учир нь, хохирогчийг буруутгах хандлагаас болж дараах сөрөг үр дагаврууд бий болдог:

- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгчид ихэнхдээ бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртсөн байдаг. Мөн нийгэмд хохирогчийг буруутгах хандлага түгээмэл байдаг учраас хохирогч ч өөрийгөө буруутгаж, сэтгэл санааны гүн хямралд орох нь элбэг.
- Сэтгүүлч ийм алдаа гаргаснаар олон нийтэд хохирогчийг буруугаар ойлгуулах, буруутгах сэдэл төрүүлдэг. Ингэснээр хүмүүс гэмт хэрэгтнийг биш, хохирогчийг буруутгаад өнгөрнө. Энэ нь хүчирхийлэгчийн үйлдлийг өөгшүүлж, дахин давтан үйлдэх сэдлийг төрүүлдэг төдийгүй хүчирхийллийг зөвтгөх буруу хандлагыг нийгэмд бий болгодог.
- Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвүүд, хамгаалах байрууд, сэтгэл зүйчид болон мэргэжлийн хүмүүс бий. Хохирогчийг буруутгах хандлагаас болж хүчирхийлэлд өртөгч сэтгэл санааны нэмэлт дарамтад орж, үйлчилгээний үр дүн буурдаг.
- Хохирогч өөрийгөө буруутайд тооцвол, эсвэл хүмүүс түүнийг буруутгахаас айвал хүчирхийллийн тухай мэдээлэх магадлал буурна. Маш олон хүн ийм шалтгаанаас болж дуугүй өнгөрч, гэмт хэрэгтэн сул чөлөөтэй үлддэг. Энэ нь хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох ажлын хамгийн том саад бэрхшээл юм.
- Хохирогч хүчирхийллийн талаар мэдээлэхээс татгалзсан тохиолдолд зохих үйлчилгээг авч чадахгүй үлдэх магадлал өндөр. Ингэснээр насан туршийн сэтгэлийн шархтай үлдэнэ, мөн хүчирхийлэл даамжирч, давтагдсаар байх магадлалтай.

Иймд, жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвийг хөндөхдөө сэтгүүлч хүн ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр баримталж, хохирогчийг буруутгах хандлагаас зайлсхийх шаардлагатай.

Ёс зүйн хэм хэмжээ ба даван туулагч төвтэй арга зүй

Даван туулагчийн эрх болон хэрэгцээ шаардлагыг хүндэтгэж, аюулгүй байдлыг хангаж, түүний эрхэм чанарыг дээдэлж харьцах таатай орчин бүрдүүлэхийг даван туулагч төвтэй арга зүй гэдэг (UNFPA, 2019). Даван туулагч төвтэй арга зүй нь дараах үндсэн зарчмуудад тулгуурладаг:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Даван туулагч болон түүний хүүхдүүдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавина. Ёс зүйтэй сэтгүүлч эх сурвалжуудтайгаа үргэлж зүй зохистой, шударга харьцаж, эмзэг байж болох эх сурвалжийг хамгаалах хариуцлага хүлээдэг. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нээлттэй ярьж, мэдээлж буй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох хүмүүс олон бий. Мөн даван туулагчдыг хүчирхийлсэн хүмүүсийнх нь зүгээс айлган сүрдүүлэх, дарамтлах, хүчирхийлэх тохиолдол элбэг гардаг. Тийм ч учраас эх сурвалжийнхаа бие махбод болон сэтгэл санааны аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, няхуур нямбай ажиллах нь хамгийн чухал. Үүнийг тантай хамт ажиллаж буй зураглаач, хэлмэрч, жолооч зэрэг хүн бүрд сайтар ойлгуулах хэрэгтэй. Түүнчлэн хүчирхийллийн талаар мэдээлэхдээ гэмт хэргийн үйлдлийг нэг бүрчлэн мэдээлэх нь энэ төрлийн гэмт хэргийн сэдлийг бий болгож, үйлдэгдэх магадлалыг өндөр болгодог аюултайг санаж байх нь зүйтэй.

НУУЦЛАЛ

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын зургаадугаарт “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана” гэж заасан. Хэнд өөрийн түүхийг ярих, эс ярихаа даван туулагч шийдэх эрхтэйг санаарай. Энэ хүрээнд эх сурвалжаасаа зөвшөөрөл авсны үндсэн дээр өгсөн мэдээллийг нь ашиглах, эш татах нь чухал.

Мөн хүчирхийллийн хохирогч болон гэр бүлийнх нь нууцыг хадгалах, хамгаалах нь мэргэшсэн, ёс зүйтэй сэтгүүлчийн үүрэг. Монгол Улс хүн ам цөөтэй учраас мэдээллийн нууцлал, хувь хүний халдашгүй байх эрхийг хангахад бэрхшээл тулгардгийг ойлгож, илүү няхуур ажиллах шаардлага бий. Хэдийгээр даван туулагчийн нэр, нүүр царайг нууцалсан ч оршин суугаа байршил, нас, ажил мэргэжил, хувцаслал, гэр бүлийн гишүүдийнх нь талаарх мэдээлэл зэргийг өгснөөр хүмүүс түүнийг таних боломжтой.

ХҮНДЭТГЭЛ

Даван туулагчийн эрх, эрхэм чанарыг дээдэлж, түүний сонголт болон хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх хэрэгтэй. Сэтгүүлчийн хувьд энэ нь эх сурвалжийнхаа хувийн нууц, хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэхийг хэлнэ. Даван туулагчийн түүхийг эрхэм чанарыг дээдлэх байдлаар хүргэхээр чармайн ажиллах бөгөөд хохирогчийг буруутгах хандлага гаргахаас дээд зэргээр сэргийлнэ. Сурвалжлагч даван туулагчийг бүрэн гүйцэд ойлгож, түүний түүхийг мэдрэмжтэй, хариуцлагатайгаар олон нийтэд хүргэснээр эргээд уншигч, үзэгчдийн ойлгох сэтгэлийг өдөөх ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Ялгаварлан гадуурхах, буруу зөвийг шүүх, шүүмжлэх нь хариуцлагатай сэтгүүлчийн хийх зүйл биш. Хүчирхийллийн талаар хэт дэлгэрэнгүй, нэг бүрчлэн мэдээлэх нь хохирогчийг буруутгах хандлагыг бий болгох эрсдэлтэй. Тухайлбал, хохирогчийн гадаад төрх, биеэ авч явах байдал болон гэмт хэрэг гарах үед өмсөж байсан хувцас зэргийг энэ талаар мэдээлэхдээ дурдах онц шаардлагагүй. Зарим сэтгүүлч бүтээлээ илүү “амьд”, нүдэнд харагдахуйц болгохын тулд иймэрхүү мэдээллийг дурдсанаас болж хохирогчийг шүүмжлэх далд санааг илэрхийлж, улмаар олон нийтэд түүнийг буруутгах сэдэл төрүүлэх нь бий.

Жендэрт суурилсан хүчирхийллийг сурвалжлахдаа баримтлах зөвлөмж

БУРУУ	ЗӨВ
<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой сэтгүүл зүйн бүтээлийн дийлэнх буюу 60 орчим хувь нь цаг үеийн мэдээ байна (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Ийм хэргийг цаг хугацаанд баригдан, дуулиан шуугиан дэгдээх зорилгоор цөөн эх сурвалжид тулгуурлан өнгөц мэдээлээд өнгөрөх нь буруу.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар учир шалтгааныг задлан шинжилсэн бүтээл гаргахад хангалттай цаг хугацаа, мэргэжлийн нөөц бололцоо зарцуулах хэрэгтэй. Шаардлагатай бүх эх сурвалжаас мэдээлэл авч, экспертүүдээс зөвлөгөө авч, хангалттай контекст мэдээлэл болон тоо баримт, нотолгоонд суурилсан даацтай мэдээ, бүтээл хийхэд анхаарч ажиллаарай.</p>
<p>Хүчирхийлэл үйлдэгч өөрийгөө буруугүй гэж харагдуулах зорилгоор мэдээлэл өгөх нь элбэг байдаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэгч, хуулийн байгууллагын өгсөн мэдээлэл дээр үндэслэн нэг талыг барьсан агуулга бэлтгэж болохгүй.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүний дуу хоолой болон даван туулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтний байр суурийг заавал оруулж байгаарай. Хэрвээ даван туулагчтай ярилцлага хийх боломжгүй бол өгүүллийг тэнцвэртэй байлгахын тулд хүчирхийллийн эсрэг ажилладаг мэргэжилтнүүд болон хуулийн байгууллагуудын мэдээлэлд тулгуурлан агуулгаа бэлтгээрэй.</p>
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг дуулиан шуугиан дэгдээх зорилгоор хөндөж болохгүй. Энэ нь сэтгүүлч бүтээлээ буруу өнцгөөс барьж авах гол шалтгаан болдог. Тухайлбал, бэлгийн дарамт, хүчирхийллийн талаарх гомдол нь олны танил, эсвэл эрх мэдэлтэй хүний нэр төрд халдах гэсэн оролдлого гэсэн өнцгөөс харж огт болохгүй.</p>	<p>Хэвлэл мэдээллийн Ёс зүйн зарчмын дөрөвдүгээрт “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана” гэж заасан байдаг.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийллийг гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил гэдэг талаас нь хөндөх шаардлагатай. Хангалттай контекст мэдээлэл, нотолгоонд суурилан яагаад ийм хэрэг гарахад хүргэснийг зөв өнцгөөс нь судалж гаргаарай.</p>
<p>Даван туулагчийг амьдралын хэв маягт нь тулгуурлан “муу”, “сайн” гэж, хийсэн үйлдэл, сонголтуудыг нь “буруу”, “зөв” гэж шүүх хандлага ажиглагддаг.</p>	<p>Хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэдгийг маш сайн ойлгож, жендэрт суурилсан хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил гэдэг өнцгөөс харах хэрэгтэй.</p>

БУРУУ	ЗӨВ
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдол, хохирогчийн талаар хэт дэлгэрэнгүй бичих алдаа элбэг гардаг. Сэтгүүлч заримдаа болсон явдлыг уншигч, үзэгчдийнхээ нүдэнд харагдтал дүрслэхийн тулд гэмт хэрэг болох үед хохирогч юу өмсөж байсан, юу хийж байсан зэргийг дурддаг. Ингэснээр нийгэмд түгээмэл байдаг хохирогчийг буруутгах хандлагыг өдөөх, гэмт хэргийн сэдэл төрүүлэх аюултай.</p>	<p>Ярилцлага, сурвалжилгынхаа явцад олж авсан бүх мэдээллээ бүтээлдээ багтаах гэж битгий яараарай. Тухайлбал, даван туулагчийн өмсөж байсан хувцас, хийдэг ажил, гэр бүлийн байдал, одоогийн болон өмнөх харилцаа, биеэ авч явах байдал зэргийг шаардлагагүй тохиолдолд дурдаж болохгүй.</p>
<p>Хүчирхийлэгчийг “урьдынхаасаа их өөр болсон”, “сэтгэцийн өвчтэй” гэдэг талаас нь дүрслэж, үйлдлийг нь зөвтгөн тайлбарлах хандлага зарим бүтээлд ажиглагддаг (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Хэрэгт шууд холбогдолгүй баримт, мэдээллүүдийг оруулснаар ийм алдаа гарах нь бий. Жишээ нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хоёр хүүхдийн эцэг Х.Х.-г маш сайн аав, халамжит хань болохыг эхнэр нь хэлэв (бусдыг хүчиндсэн хэргийн талаар хөндөж байхад түүний эхнэр, хүүхдэдээ ямар сайн ханддаг байсныг бичих шаардлагагүй). 2. Амжилттай, залуу улстөрч түүний талаар нутгийн хүмүүс нь ам сайтай байдаг. 	<p>Хэвлэл мэдээллий Ёс зүйн зарчмын 4.3-т “Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй” гэж заасан.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгчийн хувьд түүнийг ямар нэгэн байдлаар зөвтгөх, хийсэн хэргийг нь зөөлрүүлэх хандлага гаргахгүй байх нь чухал. Ялангуяа эрх мэдэл бүхий, эсвэл олны танил хүний үйлдсэн хүчирхийллийн талаар хөндөж байгаа бол түүнийг зөвтгөх, гэм буруугүй мэт харагдуулж болох мэдээллүүдийг оруулаагүй гэдэгтээ бат итгэлтэй байхын тулд дахин нягталж шалгаарай.</p>
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн олон янзын хэлбэрээс бэлгийн хүчирхийлэл болон бие махбодын хүчирхийллийн тухай мэдээг илүү хөндөж, сэтгэл санааны, эдийн засгийн зэрэг бусад хүчирхийллийн хэлбэрийг үндсэндээ орхигдуулдаг (Хэвлэлийн хүрээлэн, 2019). Мөн сэтгүүлч, редакторууд жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт муутайгаасаа болж нүдэнд илт харагдахгүй хохирлыг багасгаж дүрслэх алдаа гаргах нь бий.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт сайтай байж, биемахбод болон сэтгэл санааны хохирлыг бодитоор дүрслэх шаардлагатай. Хүчирхийллийн хохирлыг ямар нэг байдлаар багасгаж ойлгуулахаас зайлсхийгээрэй. Тухайлбал, “Хохирогч бие махбодын ноцтой гэмтэл аваагүй байна” гэж бичсэн хэсэг байвал хасахаа мартуузай.</p>

Найруулга зүй, үг хэллэгийн хувьд анхаарах зүйлс

БУРУУ	ЗӨВ
<p>Жендэрт суурилсан хүчирхийллийг даван туулагчид нь хамаатуулан бичиж БОЛОХГҮЙ.</p> <p>Жишээ: (Даван туулагчийн нэр)-ийн хүчингийн хэрэг.</p> <p>Ингэж бичсэнээр жендэрт суурилсан хүчирхийллийг өртсөн хүнд нь хамаатуулж, хариуцлага хүлээх ёстой үйлдэгчийг нь дурдалгүй өнгөрдөг.</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр өгүүлбэрээ найруулан бичээрэй.</p> <p>Жишээ: (Хүчирхийлэгчийн нэр)-ийн хүчингийн хэрэг.</p> <p>Хуулийн хүрээнд хэргийг шийдвэрлээгүй байгаа тохиолдолд “сэжигтэн”, “шүүгдэгч” гэх мэтээр бичих нь зүйтэй.</p>
<p>Даван туулагчийг үйл үгийн субъект болгон бичиж болохгүй. Ингэснээр хүчирхийлэгчийг хариуцлагаас зайлуулж харагдуулдаг.</p> <p>Жишээ: Хохирогч ажлын бус цагаар сэжигтний өрөөнд орж, улмаар хүчиндүүлжээ.</p>	<p>Хүчирхийлэгчийг өгүүлбэрийн субъект (өгүүлэгдэхүүн) байдлаар, үйл үгийг түүнд хамаатуулан бичих нь зүйтэй.</p> <p>Жишээ: Сэжигтэн хохирогчийг ажлын бус цагаар өрөөнд нь орж ирэхийг албадаж, улмаар хүчинджээ.</p>
<p>Хэргийг зөөлрүүлэх, эсвэл ойлгомжгүй болгох нэршил ашиглах нь буруу.</p> <p>Тухайлбал, гэр бүлийн асуудал, эхнэр нөхрийн маргаан, амрагийн асуудал гэх мэт ойлгомжгүй, хуулийн хариуцлага хүлээлгэж болохооргүй үг хэллэг элбэг тохиолддог.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл, биемахбодын хүчирхийлэл, хүчин зэргээр хуулийн хэллэгийг тодорхой, ойлгомжтой байдлаар ашиглаарай.</p>
<p>Үйлдлийг хэрхэн тодорхойлж байгаагаа анхаараарай. Заримдаа үг давтах алдаанаас зайлсхийхийн тулд хүчинг “бэлгийн харьцаа” гэж хольж сольж бичих алдаа гардаг. Зөвшөөрөлгүй бэлгийн харьцаанд орох, өдөх, оролдох гэх мэт тодорхойгүй, зөөлчилсөн хэл найруулга ашиглах нь буруу.</p>	<p>Бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, хүчиндэх зэргээр үйлдлийг тодорхой бичих нь зүйтэй бөгөөд үг давтах алдаанаас айх шаардлагагүй.</p>

Даван туулагчтай ярилцлага хийхдээ анхаарах зүйлс

Даван туулагчтай ярилцлага хийхдээ ямар нэгэн байдлаар хохирол учруулахгүйн тулд даван туулагч төвтэй арга зүйн зарчмуудаа эргэж харах нь зүйтэй.

Хэрхэн зөвшөөрөл авах вэ?

- Даван туулагч ярилцлага өгөхгүй байх эрхтэй. Хүчирхийллийг даван туулсан хүн сэтгэл санааны хямрал, цочролд орсон байдаг учраас ярилцлага өгөхөөс татгалзах, дурамжхан байх тохиолдол элбэг. Тийм үед ярилцлага өгөхийг ятгах, ухуулах хэрэггүй. Өөрийн зорилгыг танилцуулаад, холбоо барих мэдээллээ өгөөд л орхиорой. Шаардлагатай бол эх сурвалж төөрөө тантай холбоо барьж болно шүү дээ. Мөн хохирогчтой нүүр тулж ярилцахаас илүүтэй түүнд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн, сэтгэл зүйчээс мэдээлэл авах нь зохистой байж болно.
- Бүрэн мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл хүсээрэй⁵. Даван туулагчаас авсан мэдээллээ хаана, хэзээ, ямар форматаар гаргах агуулгад ашиглах гэж байгааг сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй. Мөн энэ агуулгыг бэлтгэх хүрээнд өөр хэнтэй ярилцах, хүчирхийлэгчээс яриа авах эсэхээ мэдэгдээрэй. Ингэснээр даван туулагч ярилцлага өгөх эсэхээ шийдэхэд туслах болно. Хэрвээ та даван туулагчийн зураг, дүрсийг авна гэж төлөвлөж байгаа бол ярилцлагаасаа өмнө зөвшөөрөл авч, хэрхэн яаж гаргааа урьдчилан тохиролцоорой. Даван туулагчийн түүхийг дараа нь өөр бүтээлдээ ашиглахаар болбол тэрийгээ мэдэгдэж, өөрөөс нь зөвшөөрөл авах шаардлагатай.

Ярилцлага хийхдээ юуг анхаарах вэ?

- Аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих. Даван туулагч болон түүний хүүхдүүд, ойр дотнын хүмүүс биемахбод болон сэтгэл санааны хохирол хүлээх аливаа эрсдэлийг нарийн тооцоолж бүх зүйлээ төлөвлөх хэрэгтэй. Үүнийг сэтгүүлчээс гадна ярилцлага хийх явцад оролцож буй хүн бүр (редактор, зураглаач, зурагчин, хэлмэрч, жолооч г.м.) ойлгосон байх нь чухал.
- Ярилцлагадаа хангалттай цаг төлөвлөх. Ярилцлага эхлэхээс өмнө ч даван туулагчид хангалттай мэдээлэл, ойлголт өгөх цаг гаргах хэрэгтэй. Зарим даван туулагч түүхээ ярих явцдаа сэтгэл нь үймэрч, хямарч мэдэх учраас сэтгэл засалч, эсвэл найз нөхөр нь хамт байх шаардлагатай бол тэр нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Ярилцлагын явцад хэцүү асуулт асуухдаа яагаад тэр асуулыг асууж байгаагаа эвтэйхэн, ойлгомжтой тайлбарлаж өгөөрэй.
- Даван туулагчийг хүндэтгэх. Сэтгүүлчийн хувьд энэ нь эх сурвалжийнхаа хувийн нууц, хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэхийг хэлж байна. Даван туулагчийн сэтгэл санаанд нэмэлт дарамт болохуйц асуулт асуух, эсвэл үйлдэл хийхгүй байх нь чухал. Хүчирхийлэлд өртсөн хүн сэтгэл санааны хүнд дарамтад орсон байдаг учраас, мөн ихэнхдээ хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах туршлага багатай байдаг болохоор юу ярих, юу ярихгүйгээ мэдэхгүй байх, тулгамдах, сандрах тохиолдол бий. Мөн сэтгэлийг нь шархлуулсан түүхийг ярих нь амаргүй байх бөгөөд жендэрт суурилсан хүчирхийлэл нь маш эмзэг сэдэв гэдгийг санаарай. Энэ бүхэнд хүлээцтэй, ойлгох сэтгэлээр хандаж, даван туулагчийг өөрийнх нь эсрэг үйлдэгдсэн хүчирхийлэлд ямар нэг байдлаар буруутгах хандлага гаргааас зайлсхийгээрэй.
- Мэдрэмжтэй байх. Таны хийж буй ярилцлага хүчирхийллийг даван туулсан хүний хэрэгцээ, шаардлагад нийцэж байна уу гэдгийг сайтар бодолцох хэрэгтэй. Зарим олон улсын байгууллагын зүгээс эмэгтэй хохирогчтой зөвхөн эмэгтэй сэтгүүлч л ярилцлага хийх нь зүйтэй гэж зөвлөдөг. Ямар ч байсан ярилцлага авч буй сэтгүүлч жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдлэгтэй байж, хохирогчийг буруутгах сэдэл төрүүлэхгүй байхад анхаарах нь чухал.
- Мэдрэмжгүй асуулт, үг хэллэг, тайлбараас зайлсхийгээрэй. “Хүчингийн хэрэг гарах үед та юу өмсөж байсан бэ? Яагаад шөнө ганцаараа явж байсан бэ?” гэх мэтийн асуулыг даван туулагчийг эвгүй байдалд оруулах, буруутгах байдлаар тавьж огт болохгүй. Тухайлбал, “Та энэ хэргийнхээ талаар цагдаад мэдэгдэхгүй яасан юм бэ?” гэхийн оронд “Цагдаад мэдэгдэх талаар бодож үзсэн үү, энэ алхмыг хийхэд тань юу саад болсон бэ?” гэж асуух нь тохиромжтой.

Ярилцлагын дараа юуг анхаарах вэ?

- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгчдөд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүдтэй холбоо барих мэдээллийг шаардлагатай бол эх сурвалждаа сануулаарай. Ийм мэдээлэл хангалттай байдаггүйгээс хохирогчид хаана, хэнд хандахаа мэддэггүй.
- Ярилцлага хийснийхээ дараа даван туулагчтай ярилцлагаа эргээд нэг дүгнэж, эргэлзэж байгаа, гаргахыг хүсээгүй мэдээлэл байгаа эсэхийг лавлаарай. Мөн редактортаа, эсвэл өөр хэн нэгэнд ярилцлагаа буулгасан хэлбэрээр үзүүлэхээсээ өмнө даван туулагчид өөрийнхөө яриаг эргэж харах боломж олгох нь зүйтэй.
- Ярилцлагаа буулгасныхаа дараа даван туулагч болон түүний үр хүүхдүүдэд эрсдэл учруулж болох мэдээлэл байгаа эсэхийг нягтлан шалгаарай. Даван туулагч хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах туршлагагүй хүн бол, эсвэл сэтгэл нь хөдөлсөндөө ойр дотны хүмүүсээ аюулд оруулж болох зүйлс ярих нь бий. Мэргэжлийн сэтгүүлч, редактор хүний хувьд та эх сурвалжийнхаа аюулгүй байдлыг дээд зэргээр бодож, эрсдэлтэй мэдээллийг хасахаа мартуузай.

Зураг, дүрс авах, сонгохдоо анхаарах нь

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ, сурвалжилгыг зурагжуулж, дүрсжүүлэх тал дээр юуны түрүүнд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дөрөвдүгээрт хэрхэн заасныг эргэж харах нь зүйтэй. Мөн даван туулагчийн зураг, дүрсийг гаргаж болох уу, болохоор бол ямар байдлаар гаргах вэ гэдэг маш том бодолцох асуудал. Энэ хүрээнд даван туулагч төвтэй арга зүйн зарчмуудаа заавал эргэж хараарай. Хэдийгээр олон улсын ихэнх байгууллага хүчирхийлэлд өртсөн хүний зураг, дүрсийг авах, олон нийтэд хүргэхийг зөвлөдөггүй ч даван туулагчтай өөртэй нь ярьж шийдэх нь зүйтэй.

Зураг, дүрс авах, сонгохдоо дараах зүйлсийг анхаараарай:

- *Ярилцлага хийхээр тохирох үедээ л зураг, дүрс авах боломж бий, эсэхийг лавлаарай. Даван туулагч өөрөө л хүсээгүй бол түүний болон түүнийг таниулж болох зураг, дүрс гаргах нь буруу. Эх сурвалж өөрөө зургаа гаргахыг хүслээ гэхэд гарч болох үр дагаврыг сайтар тайлбарлаж ойлгуулсны үндсэн дээр зөвшөөрлийг нь албан ёсоор буюу бичгээр аваарай. Ингэхдээ зураг, дүрсийг нэрээ нууцалсан, танигдуулахгүй байдлаар авах, эсэхийг мөн тодорхой ярилцаж тохирох хэрэгтэй.*
- *Хэрвээ даван туулагч нэрээ нууцлахыг хүсэж байгаа бол зураг, дүрсийг бүрэн танигдахааргүй болгох тал дээр маш сайн анхаараарай. Тухайлбал, зураг, дүрс аваад дараа нь бүдгэрүүлэх, бүрэлзүүлэх эффект оруулсан ч гэсэн тэрийг арилгаж харах боломжтой программ бий. Тиймээс зураг дүрсийг анхнаасаа л хойд талаас нь танигдахааргүйгээр, эсвэл бүдэг гэрэлтэй орчинд, хөшигний цаанаас авах гэх мэт арга хэрэглэж болно.*
- *Даван туулагчийг танигдуулах деталь мэдээлэл зураг, дүрсэнд орсон эсэхийг сайтар нягтлан шалгаарай. Тухайлбал, бэлгийн дарамтад өртсөн дунд сургуулийн сурагчийн тухай телевизээр мэдээлэхдээ нэрийг нь нууцалж, яриа өгсөн ээж, багшийнх нь царайг бүрэлзүүлсэн боловч сурвалжлагч яг сургуулийнх нь өмнө, нэр хаяг нь тодорхой харагдах байдлаар хөтөлж байв. Ингэснээр тухайн сурагчийн ангийнхан болон багш нар нь таних бүрэн боломжтой.*
- *Даван туулагчийн эрхэм чанарыг хүндэтгэх үүднээс зураг, дүрсийг ямар өнцгөөс хэрхэн авах вэ гэдгийг бодолцох шаардлагатай. Мөн зурагчин/зураглаач эргээд түүнтэй холбоо барьж, олон нийтэд хүргэх зураг/дүрсний сонголтоо хамт хийх нь зүгээр байдаг.*
- *Хэрвээ даван туулагч зураг, дүрсээ гаргахаас татгалзвал тэр сонголтыг нь хүндэтгэж үзэх ёстой. Жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвийг хөндөхдөө зурсан зураг ашиглах боломжтой. Ингэснээр асуудлын мөн чанарыг харуулах биш, дүрслэх боломж бүрддэг. Мөн ёс зүй, эрх зүйн олон асуудлыг тойрч гарах сайн талтай.*
- *Хэвшмэл ойлголтыг, эсвэл хохирогчийг буруутгах хандлагыг дэвэргэхүйц зураг дүрс гаргахаас болгоомжлоорой. Тухайлбал, согтууруулах ундаа хэрэглэж байгаа эмэгтэй хүний зураг гаргах нь хохирогчийг буруутгах сэдэл төрүүлнэ. Хоёр нүд нь хөхөрсөн, доошоо харсан эмэгтэйн зураг гаргах нь хүчирхийллийн хохирогч биемахбодын хувьд нүдэнд харагдахуйц гэмтэл авсан байдаг, эсвэл сул дорой эмэгтэй байдаг гэх хэвшмэл ойлголтыг дэвэргэнэ.*

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Жендэрийн нэр томъёоны товч тайлбар

Хүйс гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн болон генетикийн хувьд ялгагдах шинжүүдийг хамаарсан ойлголт юм. Эдгээр шинж нь /мэс ажилбар болон дааврын эмчилгээнээс бусад тохиолдолд/ хувирч өөрчлөгддөггүй.

Жендэр гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд нийгмээс бий болгосон хэм хэмжээ, үүрэг, дүр төрх, нийгмийн хандлагын ялгааг хамаарах ойлголт юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд жендэр гэдэг нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ хэмээн тодорхойлжээ.

Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухай нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрд харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Энэхүү жендэрийн хэвшмэл ойлголт нь аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг (Жендэрийн үндэсний хороо, 2018).

Жендэрийн хэм хэмжээ гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд хийж болох, болохгүй зүйлсийн талаарх нийгмийн хүлээлт юм.

Жендэрийн үүрэг, дүр төрх гэдэг нь тухайн нийгэм, хамт олон, нийгмийн бүлгийн хувьд ямар үүргийг оноож, ямар дүр төрхийг эрэгтэйлэг, эмэгтэйлэг гэж үздэгийг харуулах ойлголт юм.

Жендэрийн тэгш байдал нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх ба хүртэх боломжтой байх тухай ойлголт. Гэхдээ орчин цагт жендэрийн тэгш байдлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хандах бус, харин нөхцөл байдал, боломжийг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон. Өөрөөр хэлбэл, энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн хувьд өөр өөрийн онцлогтой ч тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм (Жендэрийн үндэсний хороо, 2018)

Жендэрийн мэдрэмж нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм (Жендэрийн үндэсний хороо, 2018).

Жендэрийн ялгаварлан гадуурхалт гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заажээ. Жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг.

Жендэрийн дүн шинжилгээ гэдэг нь бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм (Женифер Мадж, 2014).

Хавсралт 2. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, тоон мэдээлэл

Хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэн этгээд өөрийн зорилгодоо хүрэхийн тулд аль нэг давуу талаа ашиглан бусдыг болон хэн нэгнийг эрх мэдэлдээ оруулах арга хэрэгсэл бөгөөд хэн нэгнээс эрх мэдэл, хүч чадлаар давуу гэдгээ харуулахад ашигладаг.

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэгт хүйс эсхүл жендэрээс үүдэлтэй нийгмийн хүлээлт, хэм хэмжээ, хандлага, хэвшмэл ойлголт болон эрх мэдэл, хүчний тэнцвэргүй байдлын улмаас бусдын эсрэг үйлдэгдэж байгаа аливаа хүчирхийллийг ойлгоно. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн эсрэг тэднийг эмэгтэй хүн гэдэг үүднээс тэдний эсрэг үйлдэгддэг эсвэл тэдэнд тэгш бус байдлаар нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл:

- Хэн нэгнийг нийгмээс бий болгосон үүрэг, дүр төрх, нийгмийн хүлээлт, хэм хэмжээн дээр суурилан тухайн хүний эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийг жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг. Охид эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүд хөвгүүдтэй харьцуулбал нийгмээс тогтоосон хэм хэмжээ, хүлээлт, хандлагын улмаас илүү хараат (subordinate), эмзэг байдалтай байдаг нь жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид ихэвчлэн охид эмэгтэйчүүд байхад нөлөөлдөг.
- Гэхдээ хөвгүүд эрэгтэйчүүд ч мөн л нийгмийн зүгээс бий болгосон “эршүүд” шинж чанарын ойлголтын хүрээнд бий болгосон нийгмийн үүрэг, дүр төрх, хүлээлт зэргийн улмаас хүчирхийллийн хохирогч болдгийг тэмдэглэх нь зүйтэй.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хохирогчдын хүний эрхийг ноцтой зөрчиж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш бус байдлыг улам бүр нөхцөлдүүлж, ихэвчлэн амьдралынх нь туршид үргэлжлэх бие махбодын болон сэтгэл зүйн шархыг үлдээдэг төдийгүй зарим тохиолдолд үхэлд ч хүргэдэг аюултай.

Жендэрт суурилсан хүчирхийллийг охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй адил гэж ойлгож, нэр томъёог хольж сольж хэрэглэх нь бий. Эдгээр нь ямар ялгаатайг ойлгохын тулд нэр томъёоны тодорхойлолтыг харцгаая.


Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж эмэгтэйчүүдэд хувийн эсвэл олон нийтийн орон зайд бие махбодын, бэлгийн эсвэл сэтгэл зүйн сөрөг үр дагавар учруулах жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлүүдийг хэлнэ (Үндэсний статистикийн хороо, 2018). Үүнд зөвхөн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл багтдаг.


Гэр бүлийн хүчирхийлэл гэдэгт эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан байдаг.


Хүчирхийллийн хэлбэрүүд:

- Биемахбодын хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл/дарамт
- Сэтгэл санааны хүчирхийлэл/дарамт
- Эдийн засгийн дарамт

Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын талаар Үндэсний статистикийн хорооноос 2018 онд гаргасан судалгаанаас үзвэл:

 Монголд эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь амьдралынхаа аль нэг үед бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.


 Судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн 40.3 хувь нь амьдралынхаа аль нэг үед сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан бол 22.4 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн гэж хариулжээ.


 Өмнө нь хамтрагчтай байсан эсвэл одоо хамтрагчтай эмэгтэйчүүдийн 19.9 хувь нь амьдралынхаа аль нэг үед эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл төрлүүд:

Дотны харилцагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл

Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн нэг хэлбэр бөгөөд одоогийн болон өмнөх бэлгийн хамтрагчийн зүгээс бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн дайралт, эдийн засгийн дарангуйлал үзүүлэх хэлбэрээр илэрдэг.

 Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь амьдралынхаа аль нэг үед дотны харилцагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байна.

 Дотны харилцагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 42.8 хувь нь хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан бөгөөд тэдгээр эмэгтэйчүүдийн 71.6 хувь нь хүнд буюу ноцтой бэртсэн байна.

Ажлын байрны бэлгийн дарамт

Бэлгийн дарамт гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тодорхойлжээ.



Судалгаанаас үзэхэд гурван хүн тутмын нэг нь хохирогч болсон хэн нэгнийг мэддэг, таван эмэгтэй тутмын нэг нь өөрөө хохирогч болж байсан аж (Хүйсийн тэгш эрхийн төв, 2018).

Бэлгийн хүчирхийлэл

440+ Цагдаагийн байгууллагын сүүлийн хоёр жилийн тоон мэдээний дунджаар жилд 440 гаруй хүчингийн хэрэг бүртгэгдэж байна (Цагдаагийн ерөнхий газар, 2021). Үүний цаана хуулийн байгууллагад хандаагүй хэдэн хохирогч байгааг бид мэдэхгүй. Ийм гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн 11 хувь нь л хуулийн байгууллагад ханддаг гэсэн тооцоо бий (UN Women, 2013). Бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж буй энэ гэмт хэргээс болж хохирогч жирэмсэн болох, бэлгийн замаар дамжих халдвар авах, сэтгэл санааны хямралд орох зэрэг олон бэрхшээлтэй тулгардаг.



Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд онцгой анхаарах шаардлагатайг Хүний эрхийн үндэсний комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ онцолжээ. Судалгаагаар найман хүүхэд тутмын нэг нь бэлгийн шинжтэй дарамт, шахалт, сэдэл, халдлагад өртөж байсан гэж хариулсан байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2017).

57.5% 2019 онд улсын хэмжээнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг нийт 610 гэмт хэрэг, 624 хохирогч бүртгэгдсэнээс 57.5 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байгаа юм. Тухайлбал, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн таван хохирогчийн гурав, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн зургаан хохирогчийн дөрөв, хүчиндэх гэмт хэргийн 492 хохирогчийн 253 нь хүүхэд байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2020).

Хүн худалдаалах гэмт хэрэг

Хүн худалдаалах гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дагуу хэвлэл мэдээллийн байгууллага дор дурдсан зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглодог:

- Хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүй хохирогчийн талаарх мэдээлэл;
- Гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа;
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэхүйц бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашигласан ил буюу далд зар сурталчилгаа.

Хохирогч уу, даван туулагч уу?

Сүүлийн үед олон улсын байгууллагуудын зүгээс “хохилогч” биш, “даван туулагч” гэж ярьж, бичиж байхыг зөвлөж байгаа. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүнийг даван туулах чадвартай, идэвхтэй байдлаар дүрсэлдэг гэж үздэг. Харин “хохилогч” гэдэг нь тухайн хүнийг идэвхгүй, сөрөг байдлаар дүрсэлдэг хэмээн тайлбарладаг. Гэвч Монголд хуулийн хүрээнд хохирогч гэдэг үгийг ашиглаж хэвшсэн учраас “даван туулагч” гэдгийг зарим олон улсын байгууллага, ТББ л ашиглаж байна.

Хавсралт 3. Ярилцлага авах зөвшөөрлийн хуудасны загвар

_____ овогтой _____ миний бие энэхүү ярилцлагыг хэвлэл мэдээллийн _____ байгууллагын _____ нэртэй сэтгүүлчид өгөхдөө миний өгсөн мэдээллийг олон нийтэд нийтлэл/нэвтрүүлгийн хэлбэрээр хүргэхийг ойлгож, хүлээн зөвшөөрч байна.

Мэдээллийг олон нийтэд хүргэхдээ (дугуйлна уу):

- А. Миний овог, нэрийг ил гаргах
- Б. Миний овог, нэр болон намайг танигдуулахуйц мэдээллийг нууцлах

Хэрэв овог, нэрийг нууцлах бол сэтгүүлчтэй ярьж, тохирсон нууц нэрийг энд бичнэ үү:

Зураг, дүрс ашиглахдаа (дугуйлна уу):

- А. Миний зураг, дүрсийг ил гаргах
- Б. Миний болон намайг танигдуулахуйц зураг, дүрс гаргахгүй байх
- В. Зураг, дүрсийг өөр хэлбэрээр гаргах

Хэрэв зураг дүрсийг өөр хэлбэрээр гаргах бол сэтгүүлчтэй хэрхэн ярьж, тохирсон талаар мэдээллийг энд бичнэ үү:

___ (энэ хэсэгт дүрсийг бүдгэрүүлэх, дуу хоолойг өөрчлөх, орлон тоглогч ашиглах гэх мэт мэдээлэл оруулж болно)

Ярилцлагаар өгсөн мэдээлэл олон нийтэд хүрсний дараа гарч болох үр дагавартай танилцсан бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрч байна.

Ярилцлага өгсөн _____ гарын үсэг

Энэхүү мэдээллийг олон нийтэд хүргэсний дараа гарч болох үр дагаврын талаар эх сурвалждаа танилцуулсан бөгөөд ярьж тохирсныхоо дагуу эх сурвалжаа хамгаалах ёс зүйн хариуцлагыг чандлан сахих болно.

Сэтгүүлч _____ гарын үсэг

Он ... сар ... өдөр ...

Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим⁶

Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

Ёс зүйн зарчмууд	Удирдамж /тайлбар
<p>1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.</p>	<p>1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ. 1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ. 1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, ишлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана. 1.4 Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй. 1.5 Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана. 1.6 Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана. 1.7 Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцийн агуулгаас ялгаж тэмдэглэнэ. 1.8 Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно. 1.9 Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.</p>
<p>2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.</p>	<p>2.1 Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэр- гэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамга- алах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно. 2.2 Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг худал хэлэх буюу хэлэхгүй байх, дарамтлах, айлган сүрдүүлэх, сэт- гэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон тагнаж чагнахыг хамаатуулна. 2.3 Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна. 2.4 Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түүрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна. 2.5 Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.</p>
<p>3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.</p>	<p>3.1 Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ. 3.2 Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.</p>

⁶ Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт

<p>4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиан-тайгаар түгээхээс татгалзана.</p>	<p>4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ. 4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй. 4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй. 4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана. 4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй. 4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.</p>
<p>5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.</p>	<p>5.1 Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.</p>
<p>6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.</p>	<p>6.1 Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана. 6.2 Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно. 6.3 Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй. 6.4 Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй. 6.5 Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй. 6.6 Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ. 6.7 Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурьдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ. 6.8 Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.</p>
<p>7. Бусдын үй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана</p>	
<p>8. Мэдээллийн нууц эх сувалжаа чандлан хамгаална.</p>	
<p>9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.</p>	<p>9.1 Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана.</p>
<p>10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.</p>	

ЭХ СУРВАЛЖ:

- 50:50 The Equality Project. (2021). *Impact Report*.
- FEMIFESTO. (2015). *Use the Right Words: Media Reporting on Sexual Violence in Canada*.
- Fourth World Conference on Women. (1995). *The Beijing Declaration and the Platform for Action*. Beijing.
- GMMP. (2020). *Who Makes the News*.
- GMMP Methodology Guide*. (2020). Retrieved from Who makes the news?: <https://whomakesthe-news.org/>
- ICFJ. (2019). *The State of Technology in Global Newsrooms*.
- Internews, United for News. (n.d.). *Reflect Reality*.
- Kassova, L. (2020). *The Missing Perspectives of Women in News*. Bill & Melinda Gates Foundation.
- Sonke Gender Justice and Health-E News. (2017). *Reporting on Gender-Based Violence: A Guide for Journalists and Editors*. Cape Town.
- The Canadian Resource Centre for Victims of Crime. (2009). *Victim Blaming*.
- UN Women. (2013). *Factsheet: Global Progress of the World's Women, 2011-2012*.
- UNESCO. (1987). *Women and Media Decision-making: The Invisible Barriers*. Unipub.
- UNESCO. (2019). *Reporting on Violence Against Women and Girls*.
- UNFPA. (2019). *The Inter-Agency Minimum Standards for Gender-Based Violence in Emergencies Programming*.
- WACC/IFJ. (2012). *Learning Resource Kit for Gender-Ethical Journalism and Media House Policy*. Toronto.
- Глоб Интернэшнл, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2019). *Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг*. Улаанбаатар.
- Жендэрийн үндэсний хороо. (2018). *Жендэр ба бодлого төлөвлөлт*.
- Жендэрийн үндэсний хороо. (2019). *Хувийн хэвшлийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх зөвлөмж*. Улаанбаатар.
- Женнифер Мадж, Ж. Ц. (2014). *Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь: Сургагч багшид зориулсан гарын авлага*.
- Үндэсний статистикийн хороо . (2018). *Хүчирхийллийн нүцгэн үнэн: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017*. Улаанбаатар.
- ФЭС, Хэвлэлийн хүрээлэн. (2019). *Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан*. Улаанбаатар.
- ФЭС, Хэвлэлийн хүрээлэн. (2019). *Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан*. Улаанбаатар.

- ХТЭТ. (2018). Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх судалгааны тайлан. Улаанбаатар.
- ХТЭТ. (2018). Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага. Улаанбаатар.
- ХТЭТ, ЭССТ. (2018). Хохирогч төвтэй мэдээлэл: АББД, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийг эрэн сурвалжлах нь. Улаанбаатар.
- Хэвлэлийн Хүрээлэн . (2016). Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг.
- Хэвлэлийн хүрээлэн. (2017). Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцийн бодлого, сэтгүүл зүйн практик.
- Хэвлэлийн хүрээлэн. (2019). Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хэрхэн хөндөж байна вэ.
- Хэвлэлийн хүрээлэн. (2020). Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Улаанбаатар.
- ХЭҮК. (2017). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл.
- ХЭҮК. (2020). Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирсон хүүхдүүд, хэргийн шийдвэрлэлт: Баримтын дүн шинжилгээ. Улаанбаатар.
- ЦЕГ. (2021 оны June 27). Цагдаагийн ерөнхий газар: <https://police.gov.mn>
- ЮНЕСКО, Глоб Интернэшнл Төв. (2014). Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт.

